



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

## ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр, Мягмар гараг

|                                   |       |
|-----------------------------------|-------|
| Хуралдааны тэмдэглэлийн агуулга   | 1     |
| Хуралдааны товч тэмдэглэл:        | 2-28  |
| Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: | 29-71 |

- 
1. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Инновац, цахим бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/ 30-52
  2. Хүний эрхийн Үндэсний Комиссын мэдээлэл сонсох 52-71
-

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны 11 дүгээр сарын 21-ний өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 53 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адьяаа, С.Бямбацогт, Д.Ганбат, Б.Пүрэвдорж, Н.Учрал;  
Чөлөөтэй: Э.Бат-Амгалан;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Сүхбаатар;  
Тасалсан: Л.Мөнхбаатар, Ц.Сэргэлэн.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан үг хэлэв.

**Нэг.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Инновац, цахим бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх Б.Тэнгис оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, П.Хулан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хорооны асуудал хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ нар байлцав.

Төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Нэг.Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “18.4.10,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 5  |
| Татгалзсан: | 5  |
| Бүгд:       | 10 |

50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 6  |
| Татгалзсан: | 4  |
| Бүгд:       | 10 |

60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Д.Цогтбаатар:** Төслийн 1 дүгээр зүйлийн “18.4.10,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 6  |
| Татгалзсан: | 4  |
| Бүгд:       | 10 |

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “гэснийг, 18 дугаар зүйлийн 18.2.2 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 3 дугаар зүйл болгон төсөлд нэмж тусгах:

**“3 дугаар зүйл.** Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Хоёр. Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар: 1.** Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “15.2 дахь хэсэг,” гэснийг “15.2 дахь хэсгийн “хүсэлтээ бичгээр” гэсний дараа” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**2.** Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмж, зүйлийн дугаарыг өөрчлөх.

**“2 дугаар зүйл.** Арбитрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “гарын үсэг зурна.” гэснийг “гарын үсгээр баталгаажуулна.” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10

---

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Гурав.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 5 дахь заалтад доор дурдсан агуулгатай 47.4 дэх хэсэг нэмэх.

“47.4.Цаасан хэлбэрээр давхар хадгалах цахим баримт бичгийн нэр төрлийг энэ хуулийн 6.1.11-д заасан жагсаалтад тусгайлан заана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 5  
Бүгд: 10

50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10

60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Д.Цогтбаатар:** Төслийн 2 дугаар зүйлийн 5 дахь заалтад доор дурдсан агуулгатай 47.4 дэх хэсэг нэмэх.

“47.4.Цаасан хэлбэрээр давхар хадгалах цахим баримт бичгийн нэр төрлийг энэ хуулийн 6.1.11-д заасан жагсаалтад тусгайлан заана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 38.2 дахь хэсгийн “хуульд өөрөөр заагаагүй бол” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “мөн зүйлийн “4.1.14” гэснийг “4.1.15” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 5 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Дөрөв.Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “хэсэг, 33 дугаар зүйлийн 33.4.2 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэснийг “хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 33 дугаар зүйлийн 33.4.2 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж” тус тус нэмсүгэй.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Тав.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг хасаж, зүйлийн дугаарыг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.



**Зургаа.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай**  
**хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй**  
**саналын томьёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар: 1.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “заалт, 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн” гэснийг “заалтын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Долоо.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**  
**хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй**  
**саналын томьёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар: 1.**Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

---

“1 дүгээр зүйл.Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1.2 дахь заалт, 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 66 дугаар зүйлийн 66.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 66 дугаар зүйлийн 66.3.2, 66.3.3, 66.3.4 дэх заалт, 66.6 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 66.2-т заасан цахим хэлбэрээр гэж”, 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийн дараа “Тайлбар: Энэ хуульд заасан “гарын үсэг” гэж Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 4.1.14-т заасныг ойлгоно.” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

**Найм.Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурсанаар өөрчлөн найруулах.**

“1 дүгээр зүйл.Зохиогчийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэг, 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1.3 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Ес.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “6.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 6.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

**Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай** хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

**Арав.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай**  
**хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй**  
**саналын томъёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан системийг ашиглан цахим хэлбэрээр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Арван нэг.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**  
**хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй**  
**саналын томъёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

---

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар: 1.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэг,” “149 дүгээр зүйлийн 149.1.1 дэх заалт, 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэг,” “294 дүгээр зүйлийн 294.6 дахь хэсэг, 296 дугаар зүйлийн 296.2 дахь хэсэг,” “443 дугаар зүйлийн 443.16 дахь хэсэг,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

**Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Арван хоёр.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, 18.5.3 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр”” гэснийг “18.5.3 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр”” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Арван гурав.Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар: 1.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**2.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

**“2 дугаар зүйл.**Өмгөөллийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

---

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Арван дөрөв. Патентын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасаж, зүйлийн дугаарыг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 5  
Бүгд: 10  
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Д.Цогтбаатар:** Төслийн 3 дугаар зүйлийг хасаж, зүйлийн дугаарыг өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

---



Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

**Арван тав.Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурсанаар өөрчлөн найруулах.

“1 дүгээр зүйл.Прокурорын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан системийг ашиглан цахим хэлбэрээр” гэж, 34 дүгээр зүйлийн 34.3, 34.4 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 33.1-д заасан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Арван зургаа.Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар: 1.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Арван долоо.Сэжигтэн, яллагдагчийг баривчлах,  
цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай  
хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй  
саналын томьёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар: 1.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурсанаар өөрчлөн найруулах.

“1 дүгээр зүйл.Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан нийтийн мэдээллийн систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Арван найм. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар: 1.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Арван ес. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар: 1.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “3 дугаар зүйлийн 7 дахь хэсэг,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.



**Хорь. Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг,” гэсний дараах “17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэснийг хасаж, “, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Хорин нэг.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурсанаар өөрчлөн найруулах.

“1 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 5  
Бүгд: 10  
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Д.Цогтбаатар:** Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурсанаар өөрчлөн найруулах.

“1 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“17.2.Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр болон энэ хуульд заасан цахим хэлбэрээр өргөдөл гаргасан тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 12.4-т заасны дагуу ирүүлсэн баримт бичиг, эсхүл Нийтийн мэдээллийн дэд бүтцээр дамжуулан хүлээж авсан мэдээллийг хэвлэн авч, мэдээллийн санд оруулснаар хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэсэнд тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

**Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Хорин хоёр.Хууль тогтоомжийн тухай хуульд**  
**нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан**  
**зарчмын зөрүүтэй саналын томъёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурсанаар өөрчлөн найруулах.

“**1 дүгээр зүйл.**Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.10 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 21 дүгээр зүйлийн 21.11 дэх хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1.7 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 20.10-т заасан цахим хэлбэрээр” гэж, 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “38.5.4” гэснийг “38.6.4” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

**Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Хорин гурав.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар: 1.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Хорин дөрөв.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар: 1.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурсанаар өөрчлөн найруулах.

**“1 дүгээр зүйл.**Цагдаагийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 58 дугаар зүйлийн 58.6 дахь хэсгийн “дарга нь” гэсний дараа “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.



-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Хорин тав.Шүүх шинжилгээний тухай хуульд  
нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй  
саналын томъёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурсанаар өөрчлөн найруулах.

“1 дүгээр зүйл.Шүүх шинжилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**2.**Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмж, зүйлийн дугаарыг өөрчлөх.

“2 дугаар зүйл.Шүүх шинжилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “гаргаж, гарын үсэг зурж, хувийн болон байгууллагын баталгааны тэмдгээр баталгаажуулна.” гэснийг “, эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулан цахим хэлбэрээр гаргана.” гэж өөрчилсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

---

**Хорин зургаа.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан  
зарчмын зөрүүтэй саналын томьёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн доор дурдсанаар өөрчлөх найруулах.

“1 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн “төлөөлүүлэгчээс бичгээр” гэсний дараа “эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр”, 56 дугаар зүйлийн 56.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж, 41 дүгээр зүйлийн 41.7 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 162 дугаар зүйлийн 162.6 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 180 дугаар зүйлийн 180.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 162.6-д заасан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 6  |
| Татгалзсан: | 4  |
| Бүгд:       | 10 |

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт,” гэснийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 3 дугаар зүйл болгон төсөлд нэмж тусгах:

“3 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

|             |    |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 6  |
| Татгалзсан: | 4  |
| Бүгд:       | 10 |

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Хорин долоо.Эвлэрүүлэн зүүчлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар: 1.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “заалт, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн” гэснийг “заалтын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**2.**Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

**“3 дугаар зүйл.**Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

**Хорин найм.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Д.Цогтбаатар:** 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Гэрчилгээг цахим хэлбэрээр олгож болно.” гэснийг “Гэрчилгээний мэдээллийг Төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглан авах боломжтой.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

**Нотариатын хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.**

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 18 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Хүний эрхийн Үндэсний Комиссын мэдээлэл сонсох***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, Жендэрийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Т.Энхбаяр, Гомдол, мэдээлэл шалгах хэлтсийн дарга Г.Ууганбаатар, Судалгаа, дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтсийн дарга Д.Ёндонжамц нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх П.Хулан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хорооны асуудал хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Хүний эрхийн Үндэсний Комиссын мэдээллийг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Б.Энх-Амгалан, Ц.Сандаг-Очир, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Жендэрийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Т.Энхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Ц.Сандаг-Очир, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Хүний эрхийн Үндэсний Комиссын мэдээллийг сонсов.

*Уг асуудлыг 19 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 28 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 19 цаг 21 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Д.ЦОГТБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим  
16 цаг 53 минут

### **БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Д.Цогтбаатар:** Хууль зүйн байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Цэндийн Мөнх-Оргил гишүүн ирсэн, Б.Энх-Амгалан гишүүн ирсэн, Ц.Сандаг-Очир гишүүн ирсэн, Ц.Мөнхцэцэг гишүүн ирсэн, Н.Алтанхуяг гишүүн ирсэн, Ш.Раднаасэд гишүүн ирсэн, Д.Цогтбаатар гишүүн ирсэн. Нийт гишүүдийн 52.6 хувь ирсэн тул ирц бүрдсэн. Ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

**Нэг.** Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд.

**Хоёр.** Хүний эрхийн Үндэсний Комиссын мэдээллийг сонсоно.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Нэр авъя. Б.Энх-Амгалан гишүүнээр тасаллаа. Б.Энх-Амгалан гишүүний микрофоныг өгье.

**Б.Энх-Амгалан:** Эрхэм Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Өнөөдөр Зариг цэг мн-ээс санаачлаад “Дахиад өгөх амь алга. зогс” гэдэг хэлэлцүүлэг хийсэн. Хэлэлцүүлэгт намын бүлгийг төлөөлж миний бие оролцлоо.

Тэгээд хэлэлцүүлгийн үеэр хэд хэдэн зүйл яригдсан. Тэр нь цэргийн алба хааж байгаад амь нас нь эрсэдсэн, мөн бэртэж гэмтсэн хүмүүсийн асуудлаар нэлээн өргөн хүрээнд хэлэлцүүлэг болж байна.

Тэгээд үүнтэй холбоотойгоор манай Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд байгаа учраас 2023 оны 11 сарын 15-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяраар ахлуулсан шуурхай ажлын хэсэг байгуулсан юм байна.

Уг ажлын хэсэг нь Зэвсэгт хүчний анги, салбаруудад хүний амь эрсэдсэн харамсалтай үйл явдал удаа дараа болж байгаатай холбогдуулан уг асуудлыг Хүний эрхийн Үндэсний Комиссын оролцоотойгоор шалгахаар болсон юм байна.

Мөн Хүний эрхийн дэд хорооноос 2021 оны 04 сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Монгол Улсын Ерөнхийлөгч болоод Засгийн газарт зөвлөмж, чиглэл өгөх тухай тогтоол баталсан юм байна.

Тэгэхээр тогтоолын биелэлтийг болоод Б.Энхбаяр сайдаар ахлуулсан ажлын хэсгийн тайланг Байнгын хороон дээрээ сонсох нь зөв зүйтэй байна.

Үүнийг протоколд тэмдэглэж үлдээх саналтай байх юм. Дарга аа.

**Д.Цогтбаатар:** Ойлголоо. Би саналыг зарчмын хувьд ер нь зөв гэж бодож байна.

Тэр ч утгаараа сая танилцуулсан асуудал дотор хоёр дахь асуудал нь Хүний эрхийн Үндэсний Комиссын мэдээллийг сонсоно гэдэг чинь яах аргагүй өнөөдөр Та бүгдийн сая ярилцсан асуудал манай Байнгын хороон дээр үүнийг бас ярьж таарна.

Тэгээд энэ хуралдааны хуваарь чинь Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөр батлагддаг бөгөөд өнөөдрийн Та бүгдийн яригдаж байгаа хурал

зарлагдахаас өмнө түүрүүний долоо хоногт тав дахь өдөр өнөөдөр бид ингээд хэлэлцэнэ гээд тавигдчихсан байсан.

Их Хурлын дарга ч гэсэн дөрөв дэх байна уу, тав дахид чуулганы нэгдсэн хуралдаанаас энэ асуудлыг Хууль зүйн байнгын хороон дээрээ Та нар авч яриарай гэж ярьсан учраас өнөөдөр энд асуудалд орсон. Сая хоёрдугаар асуудлаар танилцуулагдаж байгаа юм.

Тэгэхээр Б.Энх-Амгалан даргын тавьж байгаа саналыг дэмжиж байна.

Тэгээд өнөөдөр ямар ч гэсэн сонсгол явагдана. Дараа нь тэр ажлын хэсгүүдийн юмнуудыг явц явцдаа, шат шатдаа сонсоод явна. Тэр нь зөв байх гэж бодож байна. Дэмжиж байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад санал сонсож дууслаа.

Хэлэлцэх асуудалдаа орё.

---

**Нэг.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг,**

*Санал, дүгнэлтээ Инновац, цахим бодлогын байнгын хороонд хүргүүлнэ!*

---

Нэгдүгээр асуудал. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулна.

Ц.Мөнх-Оргил гишүүний  
микрофоныг өгье.

**Ц.Мөнх-Оргил:** Байнгын  
хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг 2023 оны 6 дугаар сарын 09, 15-ны өдрүүдэд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд хэлэлцүүлгийн явцад хуралдаан даргалагчаас дээрх хуулийн төслүүдийг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх чиглэл өгсөн.

Хууль зүйн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 13 дугаар тогтоолоор дээрх хуулийн төслүүдийг Байнгын хорооны болгон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Г.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир нарыг тус тус томилон ажиллууллаа.

Хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсэг 2 удаа, ажлын дэд хэсэг 3 удаа хуралдаж, хуулийн төслүүдтэй нэг бүрчлэн

танилцаж, Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдэд “бичгээр” гэсний дараа “эсхүл цахим хэлбэрээр” гэж нийтлэг байдлаар тусгахаар оруулж байгаа өөрчлөлт нь тухайн хуулиар зохицуулсан харилцааны онцлог шинж чанарыг тухай бүр харгалзахгүй, цаашид хууль хэрэглээний явцад тодорхойгүй нөхцөл үүсэж болзошгүй тул хуулийн төсөл бүрийн харилцааг нарийвчлан судалж, холбогдох өөрчлөлтийг хийхээр шийдвэрлэлээ.

Ажлын хэсэг хуулийг хэрэглэх явцад үүсэж болзошгүй эрх зүйн үр дагаврыг тооцож, төрийн байгууллага хооронд болон төрийн байгууллагаас хүн, хуулийн этгээдтэй, хүн, хуулийн этгээдээс төрийн байгууллагатай, иргэд хоорондын харилцааг тус бүрээр нь ангилж холбогдох өөрчлөлтийг тусгалаа.

Тухайлбал:

**1.Төрийн байгууллага, албан тушаалтан хоорондоо цахим хэлбэрээр мэдээлэл солилцох харилцааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай нийцүүлэн тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Нийтийн мэдээллийн систем болон албаны цахим шууданг ашиглахаар өөрчлөлтийг тусгалаа.**

Жишээ нь, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн “Хянан бүртгэх үйл ажиллагаа” гэсэн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Захиргааны хэм хэмжээний актыг хянуулж бүртгүүлэхээр хүргүүлж байгаа этгээд энэ хуулийн 66.1, 66.2-т заасан баримт бичгийн бүрдлийг хангаагүй тохиолдолд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүрдлийг хангуулахаар бичгээр, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг “эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын



тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр буцаана.” гэж тусгалаа.

2.Хүн, хуулийн этгээдээс төрийн байгууллага, албан тушаалтантай харилцах харилцаанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан системүүд болон эрх зүйн үр дагавраас хамаарч Иргэний хууль болон Цахим гарын үсгийн тухай хуульд заасан цахим гарын үсэг, тоон гарын үсгийг тус тус хэрэглэхээр санал бэлтгэлээ.

Жишээ нь, Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн “Хүүхэд Монгол Улсын харьяат байх” гэсэн 7.2 дахь хэсгийн “эцэг, эхийн аль нэг нь Монгол Улсын харьяат, нөгөө нь гадаад улсын харьяат бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төрсөн тэдний хүүхэд Монгол Улсын харьяат байна. Хэрэв хүүхэд гадаад улсын нутаг дэвсгэр дээр төрсөн бол хүүхдийн иргэний харьяаллыг эцэг, эхийн харилцан бичгээр, эсвэл цахим хэлбэрээр” гэж байсныг “бичгээр, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр тохиролцооны үндсэн дээр шийдвэрлэнэ.” гэж тусгасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн “Төлөөлөгчийн бүрэн эрх” гэсэн 38.1 дэх хэсгийн “төлөөлөгчийн бүрэн эрхийг төлөөлүүлэгчээс бичгээр, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг “эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр олгосон итгэмжлэл, эрх олгосон бусад баримт бичгээр тодорхойлно.” гэж өөрчилсөн.

3.Эрх зүйн үр дагавар багатай, эсхүл тухайн салбарын хууль тогтоомжоор баталгааждаг болон хуульд амаар гүйцэтгэж болохоор тусгасан

харилцаанд аливаа хэлбэр заахгүй байхаар шийдвэрлэлээ.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 13 тоот тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгээс тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд 39 хуулийн төслөөс 28 хуулийн төсөлд холбогдох 38 зарчмын зөрүүтэй саналыг бэлтгэн Та бүхэнд танилцуулахаар тараасан болно.

Асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Холбогдох баримт бичгүүдийг ажлын хэсгээс тараасан болно. Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Ц.Мөнх-Оргил гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх Б.Тэнгис.

Ер нь сүүлийн үеийн бүх энэ цахим хөгжлийн асуудалтай холбогдсон хууль, шийдвэрүүдэд оролцож байгаа залуу байна. Хоёр дахь хүн нь ирээгүй байгаа юм байна. Тийм ээ.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. /алх цохив/

**Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **1 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. /алх цохив/

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхлэе.

**1.Төслийн 1 дүгээр зүйлийн “18.4.10,” гэснийг хасах.**

Санал хураалт явуулья. /алх цохив/

Н.Алтанхуяг гишүүн гараад явчих юм. Б.Энхбаяр гишүүн. Энэ чинь ирцээ бүрдүүлэхгүй бол. Н.Алтанхуяг гишүүнийг дууддаа, манайхан.

Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

**Б.Энхбаяр:** Уучлаарай. Сая санал хураалтын төхөөрөмж ажилласангүй. Дахин санал хураалт явуулах горимын санал гаргаж байна.

**Д.Цогтбаатар:** Тэгэхээр саяын саналыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд эхний уншсан томьёоллоор санал хураалтыг дахин явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **2 дугаар зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхлэе.

**2.Төслийн 2 дугаар зүйлийн “гэснийг, 18 дугаар зүйлийн 18.2.2 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 3 дугаар зүйл болгон төсөлд нэмж тусгах:**

**“3 дугаар зүйл.Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.”**

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **3 дугаар зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналаар санал хураалт явуулья.

**Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **1 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхлэе. Нэг саналтай.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “15.2 дахь хэсэг,” гэснийг “15.2 дахь хэсгийн “хүсэлтээ бичгээр” гэсний дараа” гэж өөрчлөх.

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхлэе. Нэг саналтай.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмж, зүйлийн дугаарыг өөрчлөх.

“2 дугаар зүйл. Арбитрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “гарын үсэг зурна.” гэснийг “гарын үсгээр баталгаажуулна.” гэж өөрчилсүгэй.”

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналаар санал хураалт явуулья.

**Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Байхгүй байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Байхгүй байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. 2 саналтай байгаа.

1.Төслийн 2 дугаар зүйлийн 5 дахь заалтад доор дурдсан агуулгатай 47.4 дэх хэсэг нэмэх.

“47.4.Цаасан хэлбэрээр давхар хадгалах цахим баримт бичгийн нэр төрлийг энэ хуулийн 6.1.11-д заасан жагсаалтад тусгайлан заана.”

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 38.2 дахь хэсгийн “хуульд өөрөөр заагаагүй бол” гэснийг хасах.

Ингэе. Сая хоёр санал зэрэг явчихлаа.

Тэгэхээр Ц.Мөнхцэцэг гишүүн горимын санал гаргачих. Үүнийг

хүчингүй болгоё гээд. Тэгээд тэрний дараа хоёр саналаа тус тусад нь явчихья.

**Ц.Мөнхцэцэг:** Саяын санал хураалт дээр миний төхөөрөмж гацсан учраас энэ санал хураалтыг хүчингүйд тооцож өгнө үү.

**Д.Цогтбаатар:** Саяын саналыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулья.

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэгэхээр ингэе. Түрүүн хоёр санал нэгдээд явчихсан учраас энэ дээр ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалтыг дахин явуулья.

**1.Төслийн 2 дугаар зүйлийн 5 дахь заалтад доор дурдсан агуулгатай 47.4 дэх хэсэг нэмэх.**

“47.4.Цаасан хэлбэрээр давхар хадгалах цахим баримт бичгийн нэр төрлийг энэ хуулийн 6.1.11-д заасан жагсаалтад тусгайлан заана.”

Энэ саналын томъёоллыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

60.0 хувиар санал дэмжигдлээ.

**2.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 38.2 дахь хэсгийн “хуульд өөрөөр заагаагүй бол” гэснийг хасах.**

Санал хураалт явуулья. Дэмжье гэсэн томъёоллоор. /алх цохив/

60.0 хувиар санал дэмжигдлээ.

**Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **3 дугаар зүйлтэй**

холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Байхгүй байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. Нэг саналтай байгаа.

**3.Төслийн 3 дугаар зүйлийн “мөн зүйлийн “4.1.14” гэснийг “4.1.15” гэж,” гэснийг хасах.**

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **4 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Байхгүй байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй байна.

**Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **5 дугаар зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Байхгүй байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй байна.

**Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн **1 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Байхгүй байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй байна.

**Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн **2 дугаар зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Байхгүй байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхлэе. Нэг саналтай байгаа.

**1.Төслийн 2 дугаар зүйлийн “хэсэг, 33 дугаар зүйлийн 33.4.2 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэснийг “хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 33 дугаар зүйлийн 33.4.2 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж” тус тус нэмсүгэй.” гэж өөрчлөх.**

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн **3 дугаар зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй байна.

**Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **1 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Байхгүй байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлэе. Нэг саналтай.

**1.Төслийн 1 дүгээр зүйлийг хасаж, зүйлийн дугаарыг өөрчлөх.**

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **2 дугаар зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал байхгүй байна.

**Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн **1 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Байхгүй байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал нэг байна.

**1.Төслийн 1 дүгээр зүйлийн “заалт, 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн” гэснийг “заалтын” гэж өөрчлөх.**

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн **2 дугаар зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн **1 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн **2 дугаар зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Зарчмын зөрүүтэй саналгүй юм байна.

**Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **1 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Байхгүй байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

**1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“1 дүгээр зүйл.Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1.2 дахь заалт, 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 66 дугаар зүйлийн 66.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 66 дугаар зүйлийн 66.3.2, 66.3.3, 66.3.4 дэх заалт, 66.6 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 66.2-т заасан цахим хэлбэрээр гэж”, 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийн дараа “Тайлбар: Энэ хуульд заасан “гарын үсэг” гэж Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 4.1.14-т заасныг ойлгоно.” гэж тус тус нэмсүгэй.”

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **2 дугаар зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Захиргааны ерөнхий хуульд**

**нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **3 дугаар зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **4 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн **1 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

**1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурсанаар өөрчлөн найруулах.**

**“1 дүгээр зүйл.Зохиогчийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэг, 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1.3 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.”**

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувиар санал дэмжигдлээ.

**Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн **2 дугаар зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **1 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

**1.Төслийн 1 дүгээр зүйлийн “6.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 6.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг,” гэснийг хасах.**

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **2 дугаар зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн

төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай** хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай** хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай** хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай** хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан системийг ашиглан цахим хэлбэрээр” гэж өөрчлөх.

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн



зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **1 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **2 дугаар зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэг,” “149 дүгээр зүйлийн 149.1.1 дэх заалт, 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэг,” “294 дүгээр зүйлийн 294.6 дахь хэсэг, 296 дугаар зүйлийн 296.2 дахь хэсэг,” “443 дугаар зүйлийн 443.16 дахь хэсэг,” гэснийг тус тус хасах.

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **3 дугаар зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **4 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн **1 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн **2 дугаар зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн **1 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн **2 дугаар зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.**

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.**

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.**

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.**

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.**

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.**

Алаг байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

**1.Төслийн 1 дүгээр зүйлийн “18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, 18.5.3 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр”” гэснийг “18.5.3 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр”” гэж тус тус өөрчлөх.**

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг” гэснийг хасах.

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“2дугаар зүйл.Өмгөөллийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.”

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Патентын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Патентын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Патентын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн

төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

1.Төслийн 3 дугаар зүйлийг хасаж, зүйлийн дугаарыг өөрчлөх.

Санал хураалт явуулья. /алх цохив/

Уначихлаа. Ц.Мөнхцэцэг гишүүн таных эсрэг гарчихаж. Ц.Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

**Ц.Мөнхцэцэг:** Миний төхөөрөмж сая санал хураалт дээр гацсан учраас саяын санал хураалтыг хүчингүйд тооцож өгнө үү.

**Д.Цогтбаатар:** Саяын санал хураалтыг хүчингүйд тооцохыг дэмжье гэж санал хураалт явуулья.

60.0 хувиар санал дэмжигдлээ.

Би дахиад томъёоллыг уншчихья.

Төслийн 3 дугаар зүйлийг хасаж, зүйлийн дугаарыг өөрчлөх.

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувиар дэмжигдлээ.

**Патентын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн

зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурсанаар өөрчлөн найруулах.

**“1 дүгээр зүйл.**Прокурорын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан системийг ашиглан цахим хэлбэрээр” гэж, 34 дүгээр зүйлийн 34.3, 34.4 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 33.1-д заасан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.”

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.**

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.**

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

1.Төслийг хууль санаачлагчид буцаах.

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувиар санал дэмжигдлээ.

**Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.**

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр**

**зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.**

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурсанаар өөрчлөн найруулах.

**“1 дүгээр зүйл.Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан нийтийн мэдээллийн систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.”**

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувиар санал дэмжигдлээ.

**Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.**

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.**

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

1.Төслийг хууль санаачлагчид буцаах.

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн **1 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “3 дугаар зүйлийн 7 дахь хэсэг,” гэснийг хасах.

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн **2 дугаар зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн **1 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг,” гэсний дараах “17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэснийг хасаж, “, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж өөрчлөх.

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн **2 дугаар зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **1 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурсанаар өөрчлөн найруулах.

**“1 дүгээр зүйл.**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.”

Санал хураалт явуулья. /алх цохив/

Ц.Мөнхцэцэг таны санал яачихаж. Микрофон Ц.Мөнхцэцэг гишүүнд өгье.

**Ц.Мөнхцэцэг:** Санал хураах төхөөрөмж маань удаа дараа гацаад байна. Саяын санал хураалт бас хүчингүй болгож өгөх хүсэлт гаргаж байна.

**Д.Цогтбаатар:** Манай техникийнхэн бас үүнийг анхаараарай. Энэ ингээд нэг бус удаа давтагдаад гарч байна.

Саяын саналыг хүчингүйд тооцё гэж санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувиар дэмжигдлээ.

Тэгээд түрүүний томьёоллоороо санал хураалт явуулья. Дэмжье гэсэн томьёоллоор. /алх цохив/

Энэ яагаад ингэчихэв. Ц.Мөнхцэцэг гишүүний юу гарахгүй байна. Тэгвэл машинаа солиод үзэх үү. Тэгье. Тэгээд горимын санал гаргачих.

**Ц.Мөнхцэцэг:** Санал хураах төхөөрөмж маань ажиллахгүй байгаа

учраас саяын санал хураалтыг бас хүчингүйд тооцож өгнө үү.

**Д.Цогтбаатар:** Саяын санал хураалтыг хүчингүйд тооцё гэж санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд түрүүний уншиж танилцуулсан томьёоллоор “дэмжье” гэж санал хураалт явуулья.

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулья. Нэг санал байна.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“17.2.Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр болон энэ хуульд заасан цахим хэлбэрээр өргөдөл гаргасан тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 12.4-т заасны дагуу ирүүлсэн баримт бичиг, эсхүл Нийтийн мэдээллийн дэд бүтцээр дамжуулан хүлээж авсан мэдээллийг хэвлэн авч, мэдээллийн санд оруулснаар хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэсэнд тооцно.”

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурсанаар өөрчлөн найруулах.

“1 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.10 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 21 дүгээр зүйлийн 21.11 дэх хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1.7 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 20.10-т заасан цахим хэлбэрээр” гэж, 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.”

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.



2. Төслийн 2 дугаар зүйлийн “38.5.4” гэснийг “38.6.4” гэж өөрчлөх.

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.**

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.**

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.**

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй**

холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.**

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.**

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.**

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.**

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн 2 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

1.Төслийг хууль санаачлагчид буцаах.

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурсанаар өөрчлөн найруулах.

**“1 дүгээр зүйл.**Цагдаагийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 58 дугаар зүйлийн 58.6 дахь хэсгийн “дарга нь” гэсний дараа “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан” гэж тус тус нэмсүгэй.”

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурсанаар өөрчлөн найруулах.

**“1 дүгээр зүйл.**Шүүх шинжилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж нэмсүгэй.”

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмж, зүйлийн дугаарыг өөрчлөх.

**“2 дугаар зүйл.**Шүүх шинжилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “гаргаж, гарын үсэг зурж, хувийн болон байгууллагын баталгааны тэмдгээр баталгаажуулна.” гэснийг “, эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулан цахим хэлбэрээр гаргана.” гэж өөрчилсүгэй.

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн доор дурдсанаар өөрчлөх найруулах.

**“1 дүгээр зүйл.**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн “төлөөлүүлэгчээс бичгээр” гэсний дараа “эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр”, 56 дугаар зүйлийн 56.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон

гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж, 41 дүгээр үйлийн 41.7 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 162 дугаар зүйлийн 162.6 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 180 дугаар зүйлийн 180.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 162.6-д заасан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.”

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн 2 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт,” гэснийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 3 дугаар зүйл болгон төсөлд нэмж тусгах:

**“3 дугаар зүйл.**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.”

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **3 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **1 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **2 дугаар зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

**1.Төслийн 2 дугаар зүйлийн “заалт, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн” гэснийг “заалтын” гэж өөрчлөх.**

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **3 дугаар зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

**2.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанар өөрчлөн найруулах.**

**“3 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.”**

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай** хуулийн төслийн **4 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай** хуулийн төслийн **1 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй нэг санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “Гэрчилгээг цахим хэлбэрээр олгож болно.” гэснийг “Гэрчилгээний мэдээллийг Төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглан авах боломжтой.” гэж өөрчлөх.

Санал хураалт явуулья. /алх цохив/

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Нотариатын хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

**Нотариатын хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дүгээр зүйлтэй** холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал алга байна.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан танилцуулна.

Ингээд эхний асуудал дууслаа.

---

### Хоёр.Хүний эрхийн Үндэсний Комиссын мэдээлэл сонсох

---

Дараагийн асуудал Хүний эрхийн Үндэсний Комиссын мэдээллийг сонсоно.

Их Хурлын дарга нэгдсэн хуралдааны үеэр Хүний эрхийн комиссын мэдээллийг сонс, сая болсон

асуудлуудтай холбогдуулаад энэ дээр ярилц гэсэн.

Хүний эрхийн Үндэсний Комиссын мэдээллийг сонс гэдэг чиглэлийг Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы үеэр Байнгын хороонд өгсөн байгаа.

---

Энэ дагуу өнгөрсөн тав дахь өдөр даргын дэргэдэх зөвлөлийн хуралдааны үеэр энэ асуудлыг хэлэлцье гэдэг асуудлыг ажлын хуваарьт оруулж батлуулсны дагуу өнөөдөр мэдээллийг сонсох үйл ажиллагаа явж байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссын мэдээллийг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан танилцуулна. 4 дүгээр микрофон.

**Ж.Хунан:** Байнгын хорооны гишүүдэд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Улсын Их Хурлын даргын 326 дугаар ангитай холбоотой Хүний эрхийн Үндэсний Комиссоос авч хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг Хууль зүйн байнгын хороонд сонсох гэдэг энэ асуудлын хүрээнд Хүний эрхийн Үндэсний Комиссоос мэдээллийг бэлтгэж Та бүхэнд танилцуулж байна.

2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Зэвсэгт хүчний 326 дугаар анги дээр байлдагч амь насаа алдсан харамсалтай хэрэг болсон.

Үүний мөрөөр Хүний эрхийн Үндэсний Комисс мэдээлэл авсан даруй холбогдох байгууллагуудтай холбогдож мэдээллийг авч ажилласан байгаа.

13-ны өдөр цагдаагийн байгууллагын зүгээс бүрэлдэхүүн ажиллаж байсан учраас хэргийн газрын үзлэгт саад болохгүйн үүднээс 13-ны өдөр Зэвсэгт хүчний 326 дугаар анги дээр очоогүй.

Харин 11 дүгээр сарын 14-ний өдөр буюу маргааш нь Хүний эрхийн Үндэсний Комисс 12 хүний

бүрэлдэхүүнтэй Зэвсэгт хүчний 326 дугаар анги дээр очиж ажилласан.

Энэ хүрээнд хэд хэдэн асуудлыг шалгаж, нөхцөл байдлыг газар дээр нь танилцсан.

Нэгд нь, юуны өмнө эрүүл мэндийн үзлэгтэй холбоотой байлдагч нарын цэрэг татлагын үеэр болон тухайн Зэвсэгт хүчний анги дээр хамрагдаж байсан эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээтэй холбоотой мэдээллийг нягталж шалгах асуудлыг хийсэн.

Тухайн үед 326 дугаар ангийн байлдагч нарыг нэгдсэн журмаар цэргийн төв госпитальд шинжилгээнд хамруулж байсан учраас тухайн карт, үзлэгийн дэвтрийг ангийн удирдлагууд авч явж тэнд байсан.

Тийм учраас үүнийг бид нягтлах боломж олдоогүй.

Үүнээс гадна тухайн анги дээр алба хааж байгаа байлдагч нартай ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулсан. Ганцаарчилсан ярилцлагыг бид 14-ний өдрийн орой 7 цагаас 10 өнгөртөл зохион байгуулж ажилласан.

138 хүнтэй ярилцлага хийх байсан учраас эхний өдөр бүгд амжаагүй.

Тийм учраас 15-ны өдрийн маргааш нь ярилцлагыг үргэлжлүүлж хийж зохион байгуулсан.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос үүнээс гадна камерын хяналттай холбоотой хяналт шалгалтыг хийсэн. Өөрөөр хэлбэл камерын хяналт хэрхэн яаж тавигдаж байгааг үзэх, тэнд дүрмийн бус харилцаатай холбоотой үйл явдал болсон эсэхийг харах зорилготой байсан.

Гэсэн хэдий ч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа учраас цагдаагийн бүрэлдэхүүн камерын хяналтыг тавьдаг. Камерын хард буюу бичлэгийг хадгалж байсан хадгалах дискийг авч явсан байсан учраас үүнийг хийх боломжгүй байсан.

Тэнд ажиллах хугацаандаа байлдагч нарын амьдардаг, амардаг байрт хяналт шалгалтыг хийсэн.

Үүнээс гадна эмнэлэг, эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг байранд хяналт шалгалтыг хийсэн.

Дээрээс нь спорт төв, тэгээд гал тогоо болон усанд орох, бие засах, ариун цэвэр сахих байгууламжид хяналт шалгалтыг хийсэн.

Үндсэндээ бидний зүгээс ямар урьдчилсан дүгнэлтийг хийсэн бэ гэхээр орчны хувьд шаардлага хангахгүй нөхцөлд 326 дугаар ангийн байлдагч нар үүрэг гүйцэтгэж байгаа юм байна гэж дүгнэсэн.

Энэ шаардлага хангасан байгууламж байхгүйтэй холбоотой, мөөгөнцөрдсөн, олон жилийн өмнө ашиглалтад орсон байрыг ашиглаж байгаатай холбоотой дүгнэлтийг хийсэн.

Анхаарал татсан хэд хэдэн асуудал цэргүүдтэй, байлдагч нартай ганцаарчилсан ярилцлага хийх үеэр гарсан байгаа. Долоо хоногт нэг удаа усанд ордог. Ялангуяа карантины үеэр долоо хоногт нэг удаа усанд оруулж байгаа нь ариун цэвэр сахихад хүндрэлтэй байна. Тэгээд өмхийрдөг, муухай үнэр гардаг асуудлууд байна гэж байгаа юм.

Цэргийн байлдагч нарын зүгээс мөн цэргийн хоолны чанартай холбоотой санал хэлж байсан. Цувдайгаар хоол хийдэг. Дээрээс нь чанар хангалтгүй байдаг асуудал байсан.

Хүний эрхийн Үндэсний Комиссын бүрэлдэхүүнийг ажиллаж байх явцад байлдагч нарын эрүүл мэндийн хувьд бүгд ханиалгасан байдалтай байсан нь анхаарал татсан.

Ханиалгаж байгаа, хатгаатай байж болзошгүй асуудлыг цөөхөн хэдэн эм өгөх замаар энэ дээр эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байгаа нь бас анхаарал татсан асуудал байсан.

Мөн камерын хяналт сулаас цэрэг, байлдагч нарын хувийн эд зүйл алга болох тохиолдлууд гардаг талаар ганцаарчилсан ярилцлагын үеэр хэлж байсан. Оюутнуудыг цэрэгт татдагтай холбоотойгоор сургалтынхаа төлбөрт санаа зовсон байлдагч нар нэлээдгүй байсан.

Тэгэхээр энэ дээр анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай. Шалгалтын ажиллагаа үргэлжилж байгаа. Бидэнд одоогийн байдлаар бичлэг ирээгүй байгаа. Дээрээс нь холбогдох мэргэжлийн байгууллагуудын дүгнэлт буюу эрүүл ахуйн дүгнэлт, онцгой байдлын, галын аюулгүй байдлын дүгнэлт ирээгүй байгаа.

Мөн байлдагч нартай холбоотой эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж байсан бүртгэл бүрэн гүйцэд ирээгүй байгаа учраас энэ дээр эцсийн дүгнэлтийг хийх арай болоогүй.

Тийм учраас эдгээр баримтуудыг ирсний ард эцэслэж, дүгнэлтээ гаргаж, тэгээд холбогдох санал, зөвлөмж шаардлагыг холбогдох байгууллагуудад

нь өгнө гэж ийм нөхцөл байдалтай ийм мэдээллийг Та бүхэнд танилцуулъя.

**Д.Цогтбаатар:** Баярлалаа. Танилцуулж байгаа асуудалтай холбогдуулан би Хууль зүйн байнгын хороонд оролцож байгаа ажлын хэсгийн албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын дарга Ц.Адъяахишиг, Жендэрийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Т.Энхбаяр, Гомдол, мэдээлэл шалгах хэлтсийн дарга Г.Ууганбаатар, Судалгаа, дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтсийн дарга Д.Ёндонжанц гэсэн хүмүүс оролцож байна.

Үндэсний хороо орж ирснийх бид энд мэдээлэл ярилцсаны дараа хоёр дахь мэдээлэл сонсмоор юмнууд бас байгаа.

Тэр нь гэхээр маргааш Улсын Их Хурал хүний эрх, жендерийн асуудлаар дүгнэлт гаргах, үнэлгээ хийх танилцуулах хурал хийх гэж байгаа.

Үүнтэй холбогдуулан маргаашийн хурлыг угтуулаад сонсох шаардлага хэрэгцээ байгаа.

Тэгээд Их Хурал, ялангуяа жендерийн асуудалд хариуцлагатай хандаж өөрөө өөртөө үнэлгээ дүгнэлтээ өгнө.

Энэ чинь олон улсын дүрмийн дагуу үнэлгээ дүгнэлтээ бид **IPU**[*Inter-Parliamentary Union*]-гийн хууль дүрэм, нормын дагуу бид хийх ёстой. Тэр дагуу хийж эхлэх гэж байгаа.

Энэ үүднээс ажлын хэсэгт энэ хүмүүсийг урьж ирүүлсэн байгаа.

Өнөөдөр хийсэн танилцуулгатай холбогдуулаад Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүдээс асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Ц.Сандаг-Очир гишүүнээр тасалъя.

Ц.Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр цэргийн албан дахь хугацаат цэргийн албан хаагч амь эрсэдсэн, хүний эрхийн зөрчлүүд гарч байгаа.

Дүрмийн бус харьцаа буюу дэглэлт гэдэг асуудал байгаа талаар Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хороо яг хоёр жилийн өмнө буюу 2021 оны 04 сарын 07-нд хуралдаж энэ хуралдаан дээр Зэвсэгт хүчний жанжин штаб, Батлан хамгаалах яам, Хүний эрхийн Үндэсний Комисс зэрэг бүх төрийн байгууллагууд оролцож нээлттэй хуралдаан хийж байсан.

Тухайн үед Хүний эрхийн Үндэсний Комиссыг төлөөлөн ирсэн Б.Энхболд гишүүн яг энэ хугацаат цэргийн албан дахь дүрмийн бус харилцаа, энэ талын гомдол мэдээлэл, Хүний эрхийн комисс хэр ирж байгаа талаар мэдээлэл өгсөн.

Ер нь хугацаат цэргийн албан дахь дүрмийн бус харилцаа байгаа учраас энэ чиглэлээр томоохон суурь судалгаа хийнэ гэдгийг мэдээлж байсан.

Тэгэхээр 2021 оноос хойш Хүний эрхийн Үндэсний Комисс цэргийн албан дахь хүний эрхийн зөрчил, дэглэлт буюу дүрийн бус харьцааны талаар ер нь судалгаа хийсэн үү?



326 дугаар ангиас гадна өмнөх хугацаанд тодорхой ангиуд дээр гарсан зөрчил, цэргийн албан хаагч амиа алдсан асуудлуудаар шаардлага, ер нь хэдэн зөвлөмж өгсөн бэ гэдгийг нэгдүгээрт асуумаар байна.

Өнөөдрийн энэ асуудал ерөөсөө зөвхөн өнөөдөр болж байгаа асуудал биш. Бас хүний эрхийн зөрчил, хугацаат цэргийн албан дахь дүрмийн бус харилцаа нэлээдгүй олон жил яригдаж байгаа.

Хүний эрхийн Үндэсний Комиссын зүгээс цэргийн албан дахь хүний эрхийг хангах чиглэлээр ер нь цаашид ямар бодлогын гэдэг юм уу, эсвэл эрх зүйн шинэчлэлүүдийг хийх нь зүйтэй гэж үзэж байгаа вэ? Энэ дээр танай комиссын байр суурийг сонсох шаардлагатай байна.

Олон түмэн, олон нийт маш их бухимдалтай байна.

Цэргийн алба Монгол Улсын аюулгүй байдал, тусгаар тогтнолын асуудал. Үнэхээр Монгол Улсын томоохон асуудал.

Тэгэхдээ хүний эрхийн зөрчилгүй, цэргийн албанд явсан хүүхдүүд маань эрүүл саруул албаа хааж, эх орныхоо хилийг, эх орноо батлан хамгаалах ажил үнэхээр нэр төрийн бөгөөд хүний эрхийн зөрчилгүй алба байх ёстой.

Гэтэл тэгж чадахгүй байгаа учраас яах аргагүй Хүний эрхийн комисс, мөн Улсын Их Хурал дахь Хүний эрхийн дэд хороо, Хууль зүйн байнгын хороо анхааран ажиллаж байна.

Хүний эрхийн комиссоос саяын хоёр асуудал дээр байр суурийг сонсох шаардлагатай байна.

**Д.Цогтбаатар:** Ажлын хэсгээс хэн хариулах вэ?

Маш чухал асуулт асуулаа шүү дээ. Та нар өмнө нь үүнийг хэр шалгаж байсан бэ? Энэ тухай та нар ямар нэгэн дүгнэлт гаргаж, холбогдох байгууллагуудад нь өгч байсан уу?

Өөрөөр хэлбэл ийм юм гарчхаар та нар гэнэт үүний хариу болгож очсон уу, эсвэл өмнө нь энэ ажлуудаа бас явуулж байсан уу, мэдээлэл дүгнэлтээ өгч байсан уу, зөвлөмжөө өгч байсан уу гэж байна шүү дээ. Энэ чухал асуулт шүү.

5 номер уу? 5 номерын микрофон өгье.

**Б.Энхболд:** Та бүхний энэ оройны мэндийг хүргэе. Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Хүний эрхийн дэд хорооноос өгсөн үүрэг чиглэлийн дагуу хугацаат цэргийн алба хаагчдын эрх, ашиг сонирхол зөрчигдөж байгаа асуудал дээр Хүний эрхийн Үндэсний Комиссыг тусгайлсан утасны дугаар, өөрөөр хэлбэл гомдол, мэдээлэл хүлээж авах чиглэлийг өгсөн.

Энэ хүрээнд Хүний эрхийн Үндэсний Комиссоос яг цэргийн алба хаагчдын эрх ашиг зөрчигдсөн, энэ дотроо сүүлийн 5 жилийн талаарх мэдээ, мэдээллийг хүлээж авахаар бид бүхэн **“92050222”** гэдэг тусгай дугаарыг Хүний эрхийн Үндэсний Комисс дээр гаргаж ажиллуулсан.

Энэ утсанд нийтдээ **4** дуудлага, гомдол мэдээлэл ирсэн.

**-2** нь хугацаат цэргийн алба хаагчидтай холбоотой.

**-2** нь байнгын цэргийн бүрэлдэхүүнтэй холбоотой, цэргийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой асуудал ирсэн.

Энэ утасны дугаар одоо болтол байнга ажиллаж байгаа. Бид бүхэн сурталчилгаа мэдээллийг нь явуулдаг.

Гэсэн хэдий ч иргэд манай Хүний эрхийн Үндэсний Комиссын **“70000222”** гэдэг дугаар луу илүү их гомдол мэдээлэл өгөх ийм хандлагатай байгаа.

Энэ ажлын хүрээнд томоохон суурь судалгааг 2021 онд яг тэр Хүний эрхийн дэд хорооны дараагаар хийсэн.

Нийтдээ цэргийн анги байгууллагын **16** анги байгууллагыг хамруулан **1500** орчим цэргийн албан хаагчдын дунд. Дээр нь эрүүгийн хэрэг үүсгэж шалгагдсан **126** кэйс дээр түүвэр судалгаа хийж, цэргийн анги, салбар дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаар дүгнэлт, саналыг Улсын Их Хуралд **21** дэх илтгэлээрээ танилцуулсан.

Энэ илтгэлтэй холбоотойгоор Улсын Их Хурлаас 49 дүгээр тогтоол гаргаж, тогтоолыг Засгийн газарт үүрэг чиглэл өгөгдсөн байгаа.

Энэ тогтоолын хэрэгжилттэй танилцах ажлын хүрээнд Хүний эрхийн Үндэсний Комисс нийтдээ **7** анги, байгууллагад тогтоолын хэрэгжилтийг шалгах хянан шалгалт зохион байгуулж **22** удаагийн цэргийн анги, байгууллагад урьдчилан сэргийлэх үзлэг, сургалтыг ингэж явуулсан.

Тогтоол дээр маш ойлгомжтой асуудал бол цэргийн алба хаагчийн амь нас хохирохгүй байх энэ асуудал дээр үүрэг, чиглэл өгсөн боловч харамсалтай нь энэ явдал ямар нэгэн шалтгаанаар

таслан зогсоогдохгүй ийм байдалтай өнөөдрийг хүртэл байж байна.

Хүний эрхийн Үндэсний Комисс **20** жилийн хугацаанд цэргийн анги, байгууллагатай холбоотой **3** удаагийн том дүгнэлтийг Улсын Их Хуралд танилцуулж, тодорхой арга хэмжээ авч байсан асуудал байгаа.

Цаашдаа цэргийн анги, байгууллагын үйл ажиллагаанд анхаарах асуудал байна.

Нэгдүгээрт нь, орчин нөхцөл, цэргийн ахуй хангамжийг эрс сайжруулах замаар ахуйн шинжтэй болон ар талын шинжтэй ажил хөдөлмөрөөс холдуулахгүй бол энэ байнгын болон золгүй байдлаар нас бардаг байдал таслан зогсоогдохгүй юм байна гэсэн дүгнэлттэй байна.

Мөн өнөөдрийн байдлаар цэргийн албанаас хохирсон хүмүүс, иргэд маш их байна. Эд нар маш их сэтгэлийн зовлон, хохирол амсаж байгаа учраас энэ дээр болж өгвөл бодлогын шинжтэй тэр тэтгэмж, нэг удаагийн асуудлуудыг бас анхаарч үзээсэй гэж бодож байна.

Өнөөдрийн хэлэлцүүлэгт энэ талаар маш тодорхой дурдаж, маш их асуудлуудыг хөндөж тавьсан байгааг Та бүхэнд уламжилж байна. Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Б.Энх-Амгалан гишүүний микрофоныг өгье.

**Б.Энх-Амгалан:** Дайны цаг биш энх цагт эр цэргийн алба хаана гээд, эх орны хүү болно гээд мордсон эрүүл саруул залуучууд амь насаа алдана гэдэг бол тун харамсалтай зүйл.

Тэр дундаа ээж, аавдаа баяртай, эр цэргийнхээ албыг хаагаад ирье гээд

инээгээд явсан хүүхэд эргээд ээж, аавдаа, ах дүүдээ цогцос болж очиж болохгүй. Энэ хамгийн чухал зүйл.

Тийм учраас бид энэ дээр сүүлийн жилүүдэд гараад байгаа энэ хэргүүдийн асуудлуудыг судлаад үзэхээр эрүүл мэндийн шалтгаанаас болсон, цэргийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, журам зөрчсөн, дүрмийн бус харьцаанаас болсон, мөн золгүй байдлаар амиа алдах, мөн амиа хорлох ийм үзэгдлүүд байгаад байна л гэж байгаа юм.

Тийм учраас өнөөдөр Хууль зүйн сайд энд ирсэн байна. Ихэнх эцэг, эхчүүдийн ярьж байгаа зүйл хууль зүйн асуудал дээр 4 юмыг л яриад байна лээ.

**Нэг дэх нь, хүн ёсоор харьцаач ээ.** Энэ цэргийн анги нэгтгэл, байгууллагуудын дарга, удирдлагууд, ахлагч офицерууд хүнтэй нэг хүн ёсоор харьцаач ээ. Зөвхөн өөрийнхөө арьсыг авч гарах гэсэн нэг ийм хандлага чинь ерөөсөө болж өгөхгүй байна гэдэг юм яриад байгаа юм.

**Хоёр дахь нь, хэргийн үнэн мөнийг тогтооход онцгой анхаарч ажиллаач.** Ялангуяа хууль, хяналтын байгууллага нь хэргийн үнэн мөнийг тогтооход ерөөсөө ажил хийхгүй байна. Шүүх, шинжилгээний юмыг өөрчилчхөөд байна. Харьцаа их муутай байна. Хөөн хэлэлцэх хугацаа дууссан гээд хаачхаад байна гэдэг асуудал ярьж байгаа юм.

Нэгэнт хүнээ алдчихсан учраас бид үүнийг үнэн мөнийг нь тогтоолгохын төлөө явмаар байна гэж яриад байгаа юм л даа.

Тэгэхээр энэ дээр хэд хэдэн чухал зүйл бий. Тэр бол цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

асуудал, зэвсэг, техникийг шинэчлэх тухай асуудал, цэргийн анги нэгтгэл, байгууллагууд дахь эрх эрх зүйн орчныг сайжруулах асуудал, цэргийн албан хаагчдын нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх, орчин нөхцөлийг нь дээшлүүлэх асуудал хэрэгтэй байгаа юм.

Сая их боломжгүй нөхцөлд алба хаадаг юм байна л гэж Хүний эрхийн комиссын дүгнэлтэд байж байна шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр энэ бүгдийг янзлах шаардлага хэрэгцээнүүд байна.

Хамгийн чухал зүйл бол одоо энэ гэмт хэргийн улмаас хохирчихсон ийм хүмүүсийн учирсан хохирлыг нөхөн олгуулах асуудлыг л их ярьж байна лээ.

Одоо тэндээс гэмтээд эрүүл мэнд нь хохирчихсон бол эрүүл мэндийн эмчилгээ, тусламж авах, эмчилгээний зардал гаргуулах асуудал. Мөн гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүс нөхөн олговор, сэтгэл санааны хохирлыг нэхэмжлэх асуудал яригдаж байгаа юм.

Тэгэхээр үүнийг одоо ингээд 2021 оны 04 сарын 06-нд гарсан тэр зөвлөмж, чиглэлийн үр дүн байж вэ гэдэг ажлын хэсгийн тайланг нэг сонсмоор байгаа юм. Тэр дагуу юу хийв гэж.

Хоёр дахь нь, Б.Энхбаяр сайдаар ахлуулсан Хянан шалгах шуурхай ажлын хэсэг гарсан юм билээ. Энэ бас Хүний эрхийн Үндэсний Комисстой хамт хийх юм билээ.

Тэгээд эдний ажлын хэсгийн бас нэг дүгнэлтийг сонсоод ингээд явахгүй бол энэ дүрмийн бус харилцаа, энэ олон шалтгаануудаас болж цэргийн амь эрсдэх, эрүүл мэндээрээ хохирох асуудал

байж болохгүй юм гэдгийг л их олон эцэг, эхчүүд ярьж байна. Энэ дээр Монголын төр бас нэг анхаарах цаг нь болжээ гэж байгаа юм.

### **Хууль зүйн сайдын багц дээр 1.8 тэрбум төгрөг л байдаг юм билээ.**

Гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүсийн нөхөн олговор гэж. Тэр хаанаа ч хүрэхгүй шүү л гэж байна лээ.

Тэгэхээр үүнийг бид тал талдаа анхаарах ийм шаардлага хэрэгцээ байна. Үүнийг Хууль зүйн сайдад уламжлаадхаарай гэж их олон эцэг, эхчүүд хэлсэн учраас би бас Байнгын хорооны хурал дээр Хууль хууль зүйн сайдад уламжилж байгаа юм. Таны ажлын хэсгийн мэдээллийг.../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** Тодруулах уу, яах уу? Санал хэллээ.

Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

**Ц.Сандаг-Очир:** Яах вэ дээ, ингээд бид ч аливаа юм болсны дараа очоод л үзэж хараад л, хяналт тавиад л, шалгаад л ингээд л явдаг.

Гандан дээр лам нарын хүүхдүүдийн асуудал болсны дараа л очоод үзэж хараад л, армид нас барсны дараа нь үзэж очоод л нэг дүгнэлт гаргадаг. Ийм байна. Тэгээд одоо асуудал гарахаас нь өмнө яаж урьдчилан сэргийлэх юм бэ гэж.

Тэгээд батлан хамгаалах цэрэг татлага ер нь үндсэндээ ардын хүүхдүүдийг бас зарим эрхийг нь хязгаарлаж ингэж тодорхой дэглэм, журмын хүрээнд ажиллуулж, хөдөлмөрлүүлдэг ийм тусгай газар.

Тэгээд энэ цэрэг татлагын товчоодын үйл ажиллагаа. Яамнаас, Жанжин штабаас тодорхой орон нутгуудын цэрэг татлагын товчоонд квот өгчихдөг.

Танайх энэ жил намрын, хаврын цэрэг татлагаар ингэ. Ингээд орон нутгийн цэрэг татлагын товчоодын дарга нар голцуу орон нутгийн Тамгын газрын дарга нар байдаг. Тэгээд квотоо гүйцээхийн тулд ажилладаг. Квотоо сайн тоондоо хүргэсэн цэрэг татлагын комисс, цэргийн штабууд сайн гээд дүгнэгддэг.

Тэгээд яг л энэ хүрээнд хүний эрхийн зөрчил хэрхэн ямархуу байна гэдгийг Та бүхэн энэ байдлаараа үзэж харав уу, үгүй юу?

Ер нь энэ манай Батлан хамгаалахын цэрэг татлагын бодлого, үйл ажиллагаа тэгээд хүссэнийг нь явуулдаг байх юм уу, хүсээгүй үед нь явуулахаар хүний эрхийн зөрчил болоод байна уу, үгүй юу?

Сая талийгчийн аав, ээжийнх нь ярьж байгаагаар үндсэндээ бараг явуулмааргүй, 3 дугаар курсийг нь оюутан байхад нь явуулсан гэсэн юм яриад гомдолтой л гэж яриад байх шиг байна лээ.

Гэх мэтчилэн явуулмааргүй, тодорхой шалтаг шалтгаантай ийм үед нь хүчээр татаад аваад явчхаж байгаа нь ер нь хүний эрхийн зөрчил хэрхэн яаж тооцогдох вэ?

Тэгэхдээ хүн болгоныг явах, явахгүй хүссэнээр нь татна гэсэн юм байна уу, үгүй юу?

Та бүхэн энэ шалгалтын үеэр зөвхөн 326 дугаар анги дээр очоод энэ

талийгчийн араас тэр тухайн орчин нөхцөлийг нь үзэж хараад л ингээд л дүгнэлт хийж байгаа.

Ерөнхийдөө манай улсын батлан хамгаалах салбарт ардын хүүхдүүдийн эрхийг хязгаарлаж, тодорхой дэглэм, сахилгын хүрээнд, энэ үйл ажиллагаанд ерөнхийд нь хүний эрхийн зөрчлийг ер нь яаж хангаж ажиллаж байна вэ гэдэг талаар Та бүхэн дүн шинжилгээ хийсэн, үзсэн юм байна уу, үгүй юу?

**“Сүүлийн 10 жилийн хугацаанд гэхэд цэргийн албанд 47 залуучууд амь насаа алдсан. Маш олон тооны залуучууд эрүүл мэндээрээ хохирсон”** гэдэг үзүүлэлт гарсан байна лээ шүү дээ.

Тэгэхээр цаашдаа ер нь 3 жилийн дэглэм, янз бүрийн дэглэлт юмнууд өнөөдрийг хүртэл байхгүй ээ гэж хэлэхэд бүрэн дүүрэн баталгаатай байж чадаж байна уу, үгүй юу?

Энэ олон залуучууд 10 жилийн хугацаанд яагаад амь насаа алдчихав? Ямар шалтаг шалтгаан байна вэ? Хүний эрхийн зөрчил талаасаа байв? Энэ олон залуучуудын амь нас эрсдэхэд. Энэ дээр Та бүхэн ерөнхий том утгаар нь дүн шинжилгээ хийж үзсэн юм байна уу?

Эхний шатын дүн шинжилгээгээр зүгээр ингээд л цус өтгөрсөн байдлаас, гэнэт зүрх хаагдах энэ тэр гээд л дүгнэлтүүд гарч байгаа л юм шиг байх юм. Яг хүний.../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** Тодруулах уу? Ажлын хэсгээс 4 дүгээр микрофон. Ж.Хунан дарга.

**Ж.Хунан:** Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулья.

Бидний өмнө хөндөж байгаагүй асуудал сая яригдлаа. Өнгөрсөн хугацаанд Хүний эрхийн Үндэсний Комиссоос зөвхөн цэргийн алба хаагчидтай холбоотой, ахуй орчин нөхцөлтэй холбоотой асуудлуудыг судалж шалгаж байсан юм билээ.

Тэгээд таны хэлсэнчлэн яг энэ цэрэг татлагын процесс маань өөрөө энэ хүний эрхийн зарчим, хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж байна уу. Бид цэрэг татлагын үед үнэхээр тэр иргэн цэргийн алба хаах эрүүл мэндийн хүндэтгэн үзэх шалтгаантай эсэхийг нь тогтоодог энэ процесс маань бас учир дутагдалтай юм билээ.

Тийм учраас энэ асуудлыг бүр нарийн судалж энэ дээр дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай гэж харж байгаа.

Өөрөөр хэлбэл эмнэлгийн комисс, өөрөөр хэлбэл хамгийн анхны цэрэг татлагын үед эмнэлгийн комисс хэрхэн үр дүнтэй ажиллаж байна вэ. Үнэхээр хууч өвчин байна уу. Цэргийн албанд очоод тэнд ачаалалтай бэлтгэл сургууль хийгээд тэр хүний бие организм дийлж байна уу, үгүй юү гэдэг дээр бид бас дүн шинжилгээ хийх ёстой юм билээ. Үүнийг үнэн бодитой хийж байна уу, үгүй юу гэдэг дээр.

Магадгүй хууч өвчинтэй байгаад, эсвэл архаг өвчинтэй байгаад цэргийн албанд очоод тэр нь илрэхгүй байж байгаад амь нас нь хохирох ийм тохиолдол байхыг үгүйсгэхгүй.

Сая ялангуяа одоо энэ ковид, цар тахлын хор нь үр нөлөө, вакцины үр нөлөөг бид бүрэн дүүрэн судалж шинжлээгүй маш олон тохиолдолд бид нарт бас цус өтгөрөлт их байна.

Тийм учраас амь нас хохирсон байж болзошгүй гэдэг ийм мэдээлэл байгаа учраас үүнийг бид мэргэжлийн эмнэлгийн байгууллагатай хамтарч энэ дээр нарийн дүн шинжилгээ хийх шаардлага байгаа.

Тэгээд үүнийг Хүний эрхийн Үндэсний Комиссоос хийхээр төлөвлөж байгаа.

Мэдээжийн хэрэг Хүний эрхийн Үндэсний Комиссоос өгсөн зөвлөмжийн дагуу гарч байгаа шийдвэрүүдийн хэрэгжилтээр Хүний эрхийн Үндэсний Комисс хяналтаа тавьдаг. Энэ хүрээндээ мөн зэвсэгт хүчний ангиуд дээр сургалт, соён гэгээрүүлэх ажил хийх явцдаа эдгээр асуудлыг бүгдийг нь хардаг, удирдлагуудтай нь ярилцдаг. Тэгээд энэ дээрээ үндэслээд асуудлыг хөндөж шууд зөвлөгөө өгөх замаар залруулах арга хэмжээг зохион байгуулдаг.

Сүүлд 2023 онд хамгийн сүүлд 49 дүгээр тогтоолын хэрэгжилтийг 4 анги дээр шалгасан. Энэ хэрэгжилтийг үндэслээд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний зөвлөмж явсан.

339 дүгээр анги, 256 дугаар анги, 017, 120 дугаар ангиуд дээр 49 дүгээр тогтоолын хэрэгжилтийг шалгаад тэгээд зөвлөмж явуулсан байгаа.

Тэгэхээр бид энэ тогтолцоогоор нь харах ёстой юм байна. Дээрээс нь бид энэ төсөв, хангамжийн асуудлыг бид хөндөх ёстой юм байна. Өнөөдөр маш олон тохиолдолд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний зөвлөмж, шаардлага хэрэгжихгүй байгаа. Энэ нь төсөвтэй шууд холбоотой байгаа гэдгийг бид тухай бүр нь хэлж байгаа.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт мөн адил төсөвтэй холбоотой гардаг.

Тэгэхээр нэг асуудал байгаа нь Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний зөвлөмж, шаардлага төсөв батлагдсаны дараа холбогдох байгууллагууд дээр очдог.../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** Нэмж хариулах уу, яах вэ? Нэмж асуух уу? Ц.Сандаг-Очир гишүүн. Микрофоныг нь өгье.

**Ц.Сандаг-Очир:** Би яах вэ, хоёр санал хэлэх гэсэн юм.

**Нэгд,** энэ армийнханд Хүний эрхийн Үндэсний Комиссоос хүний эрхтэй холбоотой чиглэлээр ахлагч офицеруудад, ангийн дарга нарт, захирагч нарт сургалт, холбогдох хүний эрхийн чиглэлийн сургалтуудыг хийх чиглэлээр Та бүхэн хөтөлбөр төлөвлөгөө гаргаж ажиллаач ээ гэж.

**Хоёрт,** яг түрүүний асуусан асуулттайгаа адилтгаад.

Ер нь хавар, намрын цэрэг татлагын үеэр хүний эрхийн зөрчлийн асуудал яг газар дээрээ ямаршуухан байна вэ? Газар дээр нь үзлэг шалгалт хийж, үнэлгээ дүгнэлт өгөх, зөвлөмж юм гаргах тал дээр Та бүхэн ирэх жилийн ажлын төлөвлөгөөндөө оруулж ажиллаач ээ гэж хоёр санал хэлэх гэж байгаа юм. Тийм.

Тэгээд ер нь манай ангийн удирдлага, захирагч нар өөрсдөө хүний эрхийн чиглэлээр.../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** Би нэг хэдэн тодорхой асуулт асуугаадахъя гэж бодож байна.

Яг энэ болсон хэрэг явдалтай холбогдуулаад шүүх эмнэлгийн дүгнэлт гүйцэд гараагүй байгаа гэж би ойлгож байгаа.

Тэгэхээр хуулийн хүрээндээ энэ шүүх эмнэлгийн үйл ажиллагаа явагдаж байна уу? Та нар тэрийг очиж анхаарсан уу? Яагаад гэвэл гол асуудлууд чинь, эсвэл будилаанууд тэндээс гарах өндөр эрсдэлтэй байгаа.

Яагаад гэвэл тэнд бодитой дүгнэлт гардаг юм бол дараа дараагийн хариуцлагын асуудал өөр түвшинд яригдаж эхэлнэ. Тэнд өөрөөр гарчих юм бол хариуцлагын асуудал шал өөр болж хувирч магадгүй. Та нар намайг юу ярьж байгааг. Нэгэнт гаднын нөлөөтэй нас барсан байна уу, эсвэл цус өтгөрөлтөөр гэх юм бол хариуцлагын асуудал шал өөр болох гээд байна шүү дээ.

Тэгэхээр түүнд чинь хэр итгэж болохуйц тэнд үйл ажиллагаа явагдаж байгаа юм? Та нар тийшээ очиж ярилцлага хийж, нөхцөл байдалтай танилцав. **Нэг.**

**Хоёр дахь асуулт.** Миний ойлгосноор та нар тэгэхээр одоо энэ Б.Энхбаяр сайдаар ахлуулсан Засгийн газар ийм ажлын хэсэг байгуулсан гэж байгаа.

Та нар үүнээс үл хамаараад өөрсдөө очоод би одоо та нарын танилцуулгаас харахад ганцаарчилсан ярилцлага уулзалт, шууд энэ үйл явдлынх нь дараа очоод хийгээд эхэлсэн байна гэж би ойлгож байна. Тэр зөв үү? Та нар өөрөөр хэлбэл өөрсдөө шууд Хүний эрхийн комиссын хувьд аливаа нэгэн засгийн шийдвэр гарахаас өмнө өөрсдөө очоод ажиллаж байсан гэсэн үг үү?

Хэрэв тэгж ажиллаж байсан бол тэнд хамт байгаа цэргүүдийн тэр сэтгэл зүйн нөхцөл байдал ямар байна вэ? Өөрөөр хэлбэл одоо дараагийн нөгөө амьд хүмүүсээ урьдчилан сэргийлэх алхмаа өнөөдөр бодоод эхэлчихсэн байх ёстой шүү дээ.

Тэгэхээр түүнтэй холбогдсон тэр хүмүүс сэтгэлийн дарамт нөхцөл байдал ямар байна? Эрсдэлд хүргэсэн тэр ахуйн нөхцөл байдал нь ямар байна? Түүн дээр та нар ямар нэгэн дүгнэлт хийсэн үү?

**Гурав дахь асуулт.** Сүүлийн 10 жилийн хугацаанд 47 гэв үү. Тийм ээ. Хүний амь эрсэдсэн байна гэдэг энэ тоо танайхаас гарсан тоо гэж ойлгож байнас. 44 үү?

Энэ 44 тохиолдолд хэдэн хүн хариуцлага хүлээсэн байна аа? Яг тодорхой тоо би асууж байна шүү. Ийм гурван асуулт асуух гэсэн юм.

4 дүгээр микрофон өгье.

**Ж.Хунан:** Хүний эрхийн Үндэсний Комисс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдоггүй.

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 22.2-т зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон эрүүгийн болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаад дуусаад эцсийн шийдвэрийг гарсан тохиолдолд Хүний эрхийн Үндэсний Комисс оролцохгүй гэдэг ийм хуулийн заалт байгаа юм.

Тэгэхээр энэ хүрээнд бид шүүх эмнэлгийн үйл ажиллагаанд хяналт тавих ийм боломж байхгүй. Процессын хуулиараа прокурорын байгууллага энэ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагааны процесс дээр хүний эрх зөрчигдөхгүй байх дээр хяналт тавьдаг.

Тийм учраас энэ дээр Хүний эрхийн Үндэсний Комиссын оролцоо хязгаарлагдмал.

Мэдээжийн хэрэг ноцтой процессын эрхүүд зөрчигдөх ийм асуудлууд яригддаг. Энэ дээр Хүний эрхийн Үндэсний Комисс хууль зөрчихгүйгээр өөрийнхөө хэмжээнд анхаарлаа хандуулж ажиглалт хийдэг. Тэгээд бүр ноцтой асуудал дээр холбогдох хяналт тавьдаг байгууллагад нь ханддаг байгаа.

Ялангуяа эрүү шүүлтээс ангид байхын эрхийн хүрээнд, хууль зүйн туслалцаа авах эрхийн хүрээнд бид холбогдох байгууллагад нь хандаж асуудлыг хөндөж тавьдаг.

Энэ 326 дугаар анги дээр болсон үйл явдалтай холбоотой Хүний эрхийн Үндэсний Комисс мэдсэн даруйд холбогдох арга хэмжээг авсан. Өөрөөр хэлбэл одоогийн бүрэлдэхүүний зарчимч, мөн Хүний эрхийн үндэсний байгууллагын өөрийнх нь онцлог хараат бусаар бие даасан байдлаар үйл ажиллагаагаа явуулна гэж байгаа.

Өөрөөр хэлбэл хөндлөнгийн хяналтыг бие дааж хэрэгжүүлнэ. Энэ утгаараа Хүний эрхийн Үндэсний Комисс аливаа байгууллагын шийд шийдвэрийг хүлээлгүй шууд ажиллах, тэгээд хяналт тавих ийм хуулийн зохицуулалттай.

Тийм учраас үүнийгээ бид хэрэгжүүлдэг байгаа. Хэнээс ч асуухгүйгээр явдаг.

326 дугаар анги дээр байлдагч нас барсантай холбоотой мэдээжийн хэрэг сэтгэл зүйн нөхцөл байдал хүнд байсан.

Ялангуяа нас бардаг байлдагчдаа нэг танхимд, тасалгаанд, өрөөнд амьдардаг байсан, унтаж байсан байлдагч нарын сэтгэл зүй гүн хямралд орсон байдалтай байсан. Ярилцлагын явцад үүнийг тогтоосон.

Тийм учраас Батлан хамгаалахын сайдад мэдэгдэж энэ дээр яаралтай арга хэмжээ авахыг зөвлөсөн. Өөрөөр хэлбэл сэтгэл заслын үйлчилгээнд хамруулах, эдгээр цэргүүдэд үргэлжилсэн хугацаанд шуурхай сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлэхийг зөвлөсөн арга хэмжээг авсан байгаа.

Сүүлийн 10 жилийн хугацаанд цэргийн анги, байгууллагад хүн амь нас хохирсон тохиолдол дээр дүн шинжилгээг хийсэн.

Тэгээд энэ дээр Б.Энхболд гишүүн дэлгэрэнгүй мэдээллийг Та бүхэнд өгнө.

**Д.Цогтбаатар:** 5 дугаар микрофон. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

**Б.Энхболд:** Хүний эрхийн Үндэсний Комисс **2021 онд** нийтдээ Эрүүгийн хэрэг үүсэж шалгагдсан **126** кэйсийг яг материалтай нь танилцсан байгаа.

Ер нь статистик мэдээгээр **44 хүний амь нас хохирсон**. Үүнээс **20 нь хугацаат цэргийн алба хаагчийн амь нас хохирсон** ийм кэйс байсан.

Манай дүн шинжилгээ хугацаат цэрэг рүү чиглэж байсан учраас бид **20** кэйсийн **15-ыг** олж материалтай нь танилцаж дүн шинжилгээ хийсэн.

Энэ **15** кэйсийг аваад үзэхээр 15-аас **4 хэрэг шүүхээр шийдэгдсэн** ийм үзүүлэлттэй байдаг. 4 хэргийг шүүхээр



шийдэхдээ **1 хэрэг нь хэрэгсэхгүй болж, 3 хэрэгт нь 4 хүн эрүүгийн хариуцлага хүлээсэн.** Ийм үзүүлэлттэй байдаг юм билээ.

**Нийт 126 кэйсийн 67 кэйс нь шүүхээр шийдвэрлэгдсэн. 44.5 хувь нь хэрэгсэхгүй болсон.**

Өөрөөр хэлбэл **“амиа хорлосон”** гэдэг юм уу, **“золгүй явдал”** байсан гэдэг ийм үндэслэлээр хэргийг хаадаг үзүүлэлт харагдсан.

Тэгэхээр энэ нөхцөл байдалтай **“хугацаат цэргийн алба хаагч”** эрүүл мэндэд хохирсон хүмүүсийн санал бодол үнэхээр нийлдэггүй болох нь өнөөдрийн хэлэлцүүлэг, энэ хавтаст хэргийн материалуудаас авдаг.

Шүүх, хуулийн байгууллага тодорхой процессынхоо дагуу шалгаад энэ бол одоо юу гэдэг юм **“гэмт хэрэг биш байна”** гээд **“хэрэгсэхгүй болгох”** тохиолдол нь **44.5** хувьтай ийм үзүүлэлт харагдаж байгаа юм.

**Д.Цогтбаатар:** Тэгэхээр танай дүгнэлтээр 44.5 хувь гэдэг бол хангалтгүй байна гэж дүгнэж байгаа юм байна шүү дээ. Тийм үү? Микрофондоо ярья.

**Б.Энхболд:** Бид прокурорын тогтоол, шүүхийн шийдвэр нь гарчихсан. Түүн дээр нь нотлох баримтуудыг нь үнэлээд хэрэгсэхгүй болгочихсон байгаа зүйлийг буруу байна гэж хэлэхээсээ илүүтэйгээр факт бол ийм байдал болсон байна.

Ер нь хүн эрүүгийн хариуцлага хүлээсэн ч бай, хүлээгээгүй ч бай яг юунаас болоод хүний амь нас хохирчов, юунаас болоод энэ эрүүл мэнд нь гэмтэл авчхав гэдэг дээр бид дүгнэлт хийж 21

дүгээр илтгэлд цогцоор нь ингэж оруулж ирсэн.

Энэ дээр цэргийн анги, байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих тогтолцоо, дээр нь энэ цэрэгтэй ажиллах арга барил, нөхцөл байдал хангалтгүй байна гэсэн дүгнэлтийг илтгэлээр гаргаж тавьсан.

Нөгөө талаасаа цөөнгүй хувь нь цэрэгт ирж байгаа иргэдийн эрүүл мэндийн асуудал, сэтгэл зүйн байдал дээр анхаарах шаардлага байна гэдгийг дүгнэлт хийгээд яг энэ чиглэлээр гурван асуудлыг Улсын Их Хурлын тогтоолд тусгуулж арга хэмжээ авхуулахаар уламжилсан байгаа.

**Д.Цогтбаатар:** Би нэг юм нэмээд асуучихъя. Энд Б.Энхбаяр дарга байж байна. Жендерийн үндэсний комисс.

**Ц.Сандаг-Очир** гишүүн ч хэлж байна. Юм болохоор л бид хойноос нь явдаг гээд.

Тэгэхээр одоо нэгэнт энэ асуудал ингээд яригдаж байгаа юм чинь өнөөдөр армийн нөхцөл байдалд, энэ жендерийн асуудал, эмэгтэйчүүдийн нөхцөл байдал, тэнд армид зөндөө олон эмэгтэйчүүд алба хааж байгаа. Тэр жендерийн тэгш байдал, эмэгтэй хүний эрхийн нөхцөл байдал ямар байна вэ? Ажлын байрны аливаа нэгэн дарамт, энэ асуудлууд чинь та нар дээр ирж байна уу? Энэ асуудлаар гомдол ирж байна уу?

Тэгээд үүнийг эртхэн ахиад дараагийн асуудал гараад энэ улс орон даяар сенсац үүсэхээс өмнө жишээлбэл үүнийг бид бас урьдчилаад харж л байх хэрэгтэй. Хэрэв тийм эрсдэл байгаа бол.

Тэгээд энэ бол зөвхөн цэрэгт биш Монголын төрийн албанд. Би хувийн байгууллагыг ярихгүй.

Нэгдүгээрт, Монголын төрийн албанд эмэгтэй хүн ажиллаж байгаа нөхцөл байдал, хүний эрхийн шаардлагаа хангасан нөхцөл байдалд байна уу? Бэлгийн аливаа нэгэн дарамт, эрсдэл байна уу? Үүнийг бид үнэхээр эртнээс олж харж байнга ярьж байх ёстой.

Тэгээд өнөөдөр бид цэргийн тухай ярьж байгаа болохоор би яг армийн хүрээнд энэ асуудлыг өөрийг чинь бас нэг танилцуулаад товчхон хэдэн үг хэлээч ээ гэж хүсмээр байна.

6 дугаар микрофон.

**Т.Энхбаяр:** Байнгын хорооны гишүүдийн энэ оройн мэндийг хүргэе.

Өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой бас Та бүхэнд нэг судалгаа хэлэх нь зүйтэй байх.

2018 онд Монгол Улсын Ерөнхий сайдаас чиглэл өгсний дагуу **монгол эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүү 9.7 жил** буюу монгол эрэгтэйчүүд эмэгтэйгээсээ даруй 10 жилээр бага насалж байгаа нь өөрөө дэлхийн дунджаас хоёр дахин өндөр байгаа хүчин зүйлсийг тодорхойл гэсэн ийм чиглэл өгсөн.

Тэгээд энэ чиглэлийг бид Үндэсний статистикийн хорооны арга зүйн зөвлөлөөр хуралдаад ерөөсөө монгол эрэгтэй, эмэгтэй хүний хамгийн эрүүл байх нас 19-өөс 25 юм байна л даа. Эрүүл байх насаа тодорхойлж оруулж ирж байгаа.

Тэгэхээр өөрөөр хэлбэл 18 нас хүртэл эцэг, эхийн хууль ёсны харгалзан

дэмжигч, асран хамгаалагчийн хүрээнд байгаа энэ хүүхдүүд өөрөө хамгийн эрүүл байх ёстой. Хяналтад доор.

Тэгээд 19-өөс 25 насны Батлан хамгаалах яамтай хамтраад цэргийн насны 10 мянган залуучуудыг хамруулаад нийслэл, 21 аймаг, үндэсний хэмжээнд энэ судалгааг хийсэн.

Судалгаа жил гаруй үйл явцын үр дүнд нийтдээ энэ оролцсон хамрагдагчдын 9600 орчим залуучуудын 58, 59 буюу бараг **60 орчим хувь нь эрүүл мэндийн асуудалтай** гэж гарсан.

Тэгэхээр өөрөөр хэлбэл 16 наснаас архи, тамхи хэрэглэх. Мөн тэгээд 10 залуу тутмын 9 нь эрүүл зөв хоол байх ёстой гэж байгаа мөртлөө 3 эрэгтэй тутмын нэг нь л энэ хооллолтыг дэмждэг.

10 эрэгтэй тутмын 9 нь дасгал хөдөлгөөн, таргалалтаасаа бид эрүүл чийрэг байх ёстой гэсэн мөртлөө энэ дээр 3 эрэгтэй тутмын нэг нь үүнийг яг хэрэгжүүлж байгаа гэсэн ийм судалгааны үр дүн гарсан байдаг.

Тэгэхээр хамгийн гол нөлөөлж байгаа хүчин зүйл нь эрүүл мэндээ урьдчилсан сэргийлэх, эрэгтэйчүүд хөвгүүд хамрагдана гэдэг нь өөрөө жендэрийн хэвшмэл ойлголт байгаа юм. Эрэгтэй хүн хүчтэй. Дорой байж болохгүй. Эрүүл мэндийн үзлэгт хамрагдах асуудал ерөөсөө хэвшээгүй.

Өөрөөр хэлбэл эмэгтэйчүүдээсээ 1.5 дахин амбулаторийн үзлэгт хамрагддаг. Тэгээд хоол зүй. Дээр нь үйлдвэрийн осол сүүлийн 2019, 2018 оныг авахад 100 хувь эрэгтэйчүүд үйлдвэрийн ослоор өртсөн гэдэг энэ үзүүлэлтүүд. Дээр нь амиа хорлох асуудлууд гэсэн. Дээр нь гэнэтийн осол

авааруудад 95 хувь нь дандаа эрэгтэйчүүд өртөж байгаа гэсэн.

Үүний суурь шалтгаан нь жендэрийн хэвшмэл ойлголт байгаа нь нийгмийн хүрээнд байна гэдэг судалгааг Та бүхэнд хэлье гэсэн юм.

**Хоёрдугаарт нь,** таны асууж байгаа асуудлын хүрээнд ер нь жендэрт суурилсан хүчирхийлэл, жендэрийн талаар ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэл батлан хамгаалах салбар дээр бид яг энэ хүрээнд Батлан хамгаалах их сургууль байгаа.

Тэгэхээр их сургууль дээр яг тусгайлсан жендэрийн талаарх модуль хичээл өнөөдөр байхгүй байна. Одоо 2023 оны Засгийн газрын тайланг бид Нийгмийн бодлогын байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо хамтарсан байдлаар сонсоно.

Тэгэхээр Дотоодын их сургууль дээр өнөөдөр жендэр судлалын тусдаа хичээлүүд ороод эхэлчихсэн.

Гэтэл Батлан хамгаалах сургууль дээр энэ байхгүй байгаа.

Тэгэхээр энэ хичээлийг бид оруулах, ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх.

Төрийн албаны албан хаагчийг чадавхжуулж байгаа Удирдлагын академийн бүх сургалт “дэс түшмэл”-ээс “тэргүүн түшмэл” хүртэлх сургалтын агуулгад жендэрийн ойлголт, мэдлэг орсон байгаа.

Батлан хамгаалах салбарт байж байгаа жендэрийн бодлого гэж байгаа. Энэ бодлого сүүлийн хоёр жил нэлээд ахицтай хэрэгжсэний гол үр дүн нь хаана гарсан бэ гэхээр томилогдож байгаа албан хаагчдын гэр бүлийн асуудал дээр

жендэрийн ажлын байрыг хөгжүүлэх чиглэлд яам анхаарч байгаа нь ахиц гэж гарсан.

Өөрөөр хэлбэл тэдний гэр бүл, эхнэр нөхөр, хүүхдүүдийн боловсрол, тэдний орлоготой байх асуудал дээр бас анхаарч байгаа.

Дээр нь энэ батлан хамгаалах салбарын ажлын байрны тохируулга. Даргын асуугаад байгаа тухайн салбарт ажиллах эмэгтэй ажил албан хаагчдын тоо нэмэгдэж байгаа. Тоо үндэсний аюулгүй байдал учраас гарахгүй байгаа.

Гэхдээ эмэгтэй албан хаагчдын тоо өсөж байгаа боловч тэнд байгаа ажиллах нөхцөл өөрөө тохируулга нь бас дэмжигдэхгүй байгаа гэдэг энэ үнэлгээ нь.../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** Баярлалаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Ц.Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Ц.Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

**Ц.Мөнхцэцэг:** Монгол Улсын иргэн Үндсэн хуульд зааснаар эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах үүрэгтэй.

Тэгээд “хугацаат цэргийн албан хаагч”-дын зарим эрхийг хуулиар хязгаарладаг энэ олон улсын стандартын дагуу хязгаарлаж байгаа.

Тэгэхдээ олон улсын болон Үндсэн хуульд заасан суурь эрхүүд, халдашгүй эрхүүд, амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, итгэл үнэмшилтэй байх, эрүү шүүлтээс ангид байх, хүнлэг бус хэрцгий байдлаас ангид байх эрхүүд ерөөсөө зөрчигдөх ёсгүй.

Гэтэл Хүний эрхийн Үндэсний Комиссын судалгаанууд болон өнгөрсөн

жилүүдийн олон ноцтой кэйс зөрчлүүдээс үзэхэд ер нь хугацаат цэргийн албанд хүний эрхийн зөрчил маш түгээмэл байна. Тухайлбал, Хүний эрхийн Үндэсний Комиссын 21 дүгээр илтгэлд дурдсанаар бие махбодын хүчирхийлэл буюу дүрмийн бус харьцаа, дэглэлт. Дахиад дээр нь сэтгэл санааны хүчирхийлэл асар их байгааг тэр судалгаанд оролцсон цэргүүдэд маань дурдаж байсан байна.

Хуучны олон түмний дунд ярьдгаар дэгдэлт гэдэг бол цэргийн алба нь байх ёстой гэдэг энэ бурангуй хандлага маань хүртэл байгаад байх шиг байна.

Цэргийн алба хаах, цэргийн дотоод хяналт, үнэлгээ, шинжилгээний газрууд маань хангалттай ажиллахгүй байх шиг байна.

Тэгээд цэргийн албанд хийх ёсгүй гэдэг юм уу, тухайн цэргийн алба хаах хуулиар зөвшөөрөгдсөн үйлдлээс бусад үйлдлүүдийг шаардах, шийтгэх. Энэ шийтгэл дотор хүнлэг бус харьцаж байгаа. Өвлийн хүйтэн болон хэт халууны улиралд бие махбодын томоохон шийтгэлүүд үзүүлэх. Халууны цагт бэлтгэл сургуулийн цагийг уртасгах зэрэг ийм ноцтой зөрчлүүд байгаад байна.

Тийм учраас ер нь энэ хугацаат цэргийн албан дахь хүний эрхийн зөрчил гэдгийг бид өргөн хүрээтэй харж, энэ зөрчлөөс сэргийлэхийн тулд цэргийн албаны хууль байна уу, эсвэл Зэвсэгт хүчний тухай хууль байна уу, мөн цэргийн албан дахь дотоод дүрэм журмыг сайжруулах шаардлага байна.

Сая 326 дугаар ангид гарсан цэргийн амиа алдсан хэрэгтэй холбогдуулан мэдээллүүд нэлээн явж

байна. Энэ талаар манай хэвлэл мэдээллийн байгууллагууд сурвалжилж тодорхой мэдээллүүдийг хохирогчид болон өмнөх жилүүдэд бас амь насаа алдсан, хохирсон цэргийн албан хаагчдын эцэг эх, гэр бүлийн төлөөллүүдийн мэдээллийг бид нарт ирүүлж байна.

Ингээд харахаар ер нь цэргийн албан дахь тэр дотоод хяналт, шинжилгээ нь ерөөсөө маш тааруу байна. Яягүй олон тохиолдол. Тэр цэргийн албан дахь хүний эрхийн зөрчил болон эрүүгийн гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдол бас хэрэгсэхгүй болох.

Түрүүн манай гишүүд хэлж байсан. Шүүх шинжилгээний дүгнэлтүүд зарим тохиолдолд “хохирогчийн буруу” гэдэг юм уу, эсвэл “золгүй үхэл” нэрээр хэрэг хаах юмнууд их гарч байна.

Тийм учраас эрүүл, аюулгүй. Цэргийн хүн халдашгүй эрхүүдээ эдлэх ёстой. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндийн туслалцаа авах хэрэгтэй байгаа.

Гэтэл сая тэр 326 дугаар ангид гарсан хэргийн дараа нэлээд олон хугацаат цэргийн албан хаагч нар эмнэлгийн үзлэгт ороход их олон цэргүүд маань ханиадтай хатгаатай буюу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авч чадахгүй байна. Энэ бол үнэхээр ноцтой шүү.

Тэгэхээр тухайн тэр цэргийн албан дахь хүний эрхийнх нь нөхцөл ямар гүнзгий түгээмэл байгаа нь харагдаж байна.

Тийм учраас бид хугацаат цэргийн алба хааж байгаа хүний эрхийг бүх талаар хамгаалах шаардлага байна. Энэ чиглэлээр бас Хууль зүйн байнгын хороо,

Хүний эрхийн дэд хороо анхааран ажиллаж дараа дараагийн дэвшил реформуудыг хийх нь зүйтэй болов уу гэж бодож байна.

**Д.Цогтбаатар:** Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

**Ц.Сандаг-Очир:** Энэ асуудал үүссэнтэй холбоотойгоор Хүний эрхийн Үндэсний Комисс энэ арми, цэргийн анги, байгууллагууд, нэгтгэлүүд дээр хүний эрхийн чиглэлээрээ онцгой сайн анхаарал хандуулж ажиллаж, ахиж хүний амь нас эрсдэхгүй байх, энэ зөрчлийг, энэ гэмт хэргийг гаргахгүй байх, таслан зогсоох арга хэмжээг авахгүй бол ямар ч эцэг, эх хүүхдээ хугацаат цэргийн албанд явуулах хүсэл сонирхол байхгүй болно.

Энэ нь эргээд Монгол Улсын батлан хамгаалах салбар бодлого, үйл ажиллагаанд сөрөг үр дагавартай ийм хандлагыг нийгэмд бий болгоно.

Тийм учраас Та бүхэн энэ асуудал үүссэн дээр Батлан хамгаалах яам, Хууль зүйн яамтайгаа хамтарч энэ салбарынхантай хүний эрхийн чиглэлээр дотоод сургалт, хөтөлбөрт нь хүний эрхийн чиглэлээр. Сая ярьж байна шүү дээ. Сургалтын хөтөлбөрт нь жендэрийн чиглэлээр ямар ч хөтөлбөр юм байхгүй байна л гэж байна. Хүний эрхийн чиглэлээр тэгвэл сургалтын хөтөлбөрт нь байна уу. Байхгүй л байгаа байх. Бараг.

Тэгэхээр энэ чиглэлээр дорвитой ажиллаж арга хэмжээ авахгүй бол ямар ч эцэг, эх цаашлаад хүүхдээ цэргийн алба хаагаад ир ээ гээд явуулах тэр хүсэл сонирхол байхгүй болно шүү. Энэ дээр Та бүхэн онцгой анхаарч ажиллаач ээ.

Тэр ч үүднээс өнөөдөр энэ үндэсний аюулгүй байдлын хэмжээний асуудал байгаа учраас Их Хурлын даргын

зүгээс тодорхой чиглэл үүрэг өгч Хууль зүйн байнгын хороог Хүний эрхийн комиссын чиглэлээр, энэ чиглэлээр ямар арга хэмжээ авсан байна вэ гэдгийг сонс гэж өнөөдрийн Байнгын хорооны хурлаар энэ асуудлыг оруулж байгаа гэж ойлгож байна.

Тийм учраас Та бүхэн маань дараа дараагийнхаа хяналт шалгалтын үйл ажиллагаандаа энэ ажлаа эрчимжүүлэх хэрэгтэй байна.

Нөгөө талаар зөвхөн цэрэг арми биш хүний эрхийн зөрчил гарч болох ямар салбар нэгжүүд байгууллагууд байна вэ гэж. Тухайлбал, би ахмадын асран халамжийн төвүүд гэж байна, хүүхдийн асран халамжийн төвүүд гэж байна.

Энэ дээр бас хүний эрх, хүүхдийн эрх, ахмадуудын эрхийг зөрчих тодорхой дэглэм, хязгаар байх ийм асуудлууд бас ам хоорондоо дамжаад яригддаг асуудлууд бий шүү. Ил гарахгүй л байгаа болохоос биш.

Гэх мэтчилэн өөр хаана ямар салбарт хүний эрхийн зөрчил байж болох вэ. Хэдүүлээ араас нь хөөцөлдөх биш урьдчилж харж хүний эрхийн зөрчил үүсэж болох, суурь эрхийн зөрчил үүсэж болох салбар нэгжүүдийг бүр онилж хараа оноондоо авч ингэж жилийн төлөвлөгөө юмандаа оруулах.

Би танай ирэх жилийн төсөв төлөвлөгөө бас боловсрогдож байгаа байлгүй. Хяналт шалгалтын төлөвлөгөө.

Би бол энэ ахмадын амралт, асрамжийн газар, хүүхдүүдийн асрамжийн газарт танайхыг бас хяналт шалгалт хийх чиглэлээр санал өгмөөр байна. Ирэх жилийн 2024 оны ажлын төлөвлөгөөнд нь. Зүгээр миний бодож

байгаа нь энэ. Өөр салбар юмнууд байхыг үгүйсгэхгүй байх.

Үүндээ Та бүхэн ирэх жилийн ажлын төлөвлөгөөндөө оруулж өгвөл сайн байна л гэж хэлэх гэж байгаа юм. Тэгээд үйл ажиллагаагаа эрчимжүүлэх хэрэгцээ шаардлага зайлшгүй л байна даа. Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Баярлалаа. Би нэг хэдэн зүйл хэлээдэхье гэж бодож байна.

Нэгдүгээрт, шүүх эмнэлгийн үйл ажиллагаа. Мэдээжийн хэрэг мөрдөн байцаах үйл ажиллагаанд та нарын эрх хэмжээ хязгаарлагдсан байгааг би ойлгож байгаа. Энэ асуудлыг та нар чинь бас хөндөж ярьж байсан. Бид нарт энд тодорхой үүд хаалгыг нээж өгөхгүй бол энэ рүү чинь бид орж чадахгүй байна шүү.

Тэгэхээр хүний эрх хамгийн их тэнд зөрчигдөж байгаа. Тэрийг мэдсээр байж бид тийшээ оръё гээд ч хуулиараа хаагдчихсан. Орж болохгүй байгаад байгаа шүү гээд.

Тэгээд Хууль зүйн сайдад үүнтэй холбогдуулаад бас нэг зүйл хэлмээр байна.

Энэ дээр бусад орны жишгүүдийг харж байгаад хэр хэмжээнд үүнийг нээж өгөх боломж байна? Нээрээ хүний эрх хамгийн их тэнд зөрчигдөж байх эрсдэл байгаа учраас энд тэр боломжийн хэмжээнд нь үүд хаалгыг яаж нээж өгч болохоор байна? Энэ дээр бас шийдэл сайдаа бодож байх хэрэгтэй. Зүгээр болохгүй гээд хаачих шиг амар юм байхгүй.

Тэгэхдээ бас олон нийтийн хараа хяналт. Ялангуяа би зүгээр хаа хамаагүй хараа хяналт яриагүй байна. Угаасаа

Хүний эрхийн комисс гээд Монгол төр өөрөө хараат бусаар байгуулж өгчхөөд тэгээд түүндээ итгэлээ гүйцэд өгөх хэрэгтэй.

Тэгэхээр тэр боломжийг нэг судлаарай гэж яг энэ боломжийг ашиглаад бас Хууль зүйн сайдад хэлмээр байна. Эд нар нэг бус удаа тавьж байгаа.

Нэгэнт шүүх эмнэлгийн ажиллагаанд эд нар оролцох боломжгүй юм чинь энэ удаад сайд аа, та өөрөө угаасаа ажлын хэсгийн дарга болчихсон байгаа учраас үүнийгээ сайн анхаараарай. Тэнд чинь хамаг будилаан. Тэнд юм өөрчлөгдөөд л бүх юм сууриараа өөрчлөгдөж байна шүү дээ, угаасаа.

Тэгэхээр тэрийгээ та нэг сайн харна биз. Танай салбар үүнтэй байнгын холбоотой ажиллаж байдаг учраас мэдээжийн хэрэг Эрүүл мэндийн яамтайгаа ажиллана биз.

Хүний эрхийн комиссынхон одоо ингээд төрөөс ямар нэгэн шийдвэр гаргахыг хүлээлгүйгээр шууд явж очоод өөрсдөө тэндээ даруй ажлаа эхэлчихсэн байсан бол их сайн байна.

Тэгээд үүгээр энэ судалгаа юмнуудаа хийгээд явж байсан бол сайн байна.

Хэзээ бид нарт үүрэг чиглэл өгөх вэ гэдгийг хараагүй байна гэдэг чинь чухал.

Энэ дээр зүгээр нэг зүйлийг хэлмээр байгаа юм. Б.Энхбаяр сайд аа, бас үүнийг бодоорой.

Би чинь хэвлэл мэдээлэлтэй явж байгаа. Ерөнхий сайдаас шийдвэр гараад энэ Хүний эрхийн комиссоо хамтатгаад

ажлын хэсэг байгуулсан байх шиг байсан. Тийм ээ.

Тэгэхээр эд нарын сая хэнээс ч асуулгүй өөрсдөө очоод ажилласан нь яг зөв. Ямар утгаар би хэлж байна гэхээр эд нарт чинь үүрэг өгдөг байгууллага нь төр биш шүү дээ.

Ажлын хэсэгт орох уу, үгүй юу гэдгийг чинь. Эд нар чинь нөгөө хараат бус юм чинь төрийн аливаа нэгэн байгууллага өөрөө шийд гаргаж эдэнтэй зөвшилцөж эдний саналыг авалгүйгээр өөрсдөө шууд шийдвэр гаргаж болохгүй.

Тэгэхээр энэ дээр эд нар би нээлттэй байгаа гэж бодож байна. Эд нартайгаа ярилцаад тэр ажлын хэсэгтээ оруулах байх.

Тэгээд энэ дээрээ хамтраад цаашаа ажиллана биз. Эд нарын одоо хийж байгаа ажил чинь гүйцэд дуусаагүй байна. Тэр гүйцэд дүгнэлтүүдээ гаргаад авчирч танилцуулаарай. Хууль зүйн байнгын хороон дээр. Би үүнтэй танилцахад бэлэн байна.

Энэ хамт байсан цэргүүдтэй нь ярилцлага хийж, зөвлөмж өгсөн байна. Энэ их чухал. Яагаад гэвэл одоо амьд байгаа хүмүүсээ хамгаалах цаг. Тэгээд тэр хүмүүсийн сэтгэл зүйн гүн дарамтад байгаа энэ нөхцөл байдлыг анхаарч одоо тэр сэтгэл зүйн зөвлөгөө өгч, тэр сэтгэл зүйн гутралаас нь үнэхээр хамгаалж ажиллахгүй бол болохгүй.

Үүнтэй холбогдуулаад Ц.Мөнхцэцэг гишүүндээ бас үүрэг өгмөөр байна. Хүний эрхийн дэд хорооны даргын хувьд Хууль зүйн байнгын хорооноос ямар үүрэг өгмөөр байна гэхээр одоо яг энэ Хүний эрхийн комисстойгоо хамтраад, Хууль зүйн

яамтайгаа хамтраад энэ ажил дээр бас та хүч өгч ормоор байна. Хяналт тавьж.

Ялангуяа одоо би тэр шүүх эмнэлэг дээр эргэлзэж байгаа шүү. Түүн дээр нь анхаарал тавьж ажиллах нь маш зөв байгаа.

Тэгээд нэг зүйл хэлмээр байна. Хилийн цэрэг дээр. Одоо бид чинь юмыг нэгэнт урьдчилж харъя л гэж ярьж байгаа бол хилийн цэрэг дээр очиж дүгнэлт, дүн шинжилгээгээ Хүний эрхийн комиссынхон хийвэл би зүгээр байх гэж бодож байна. Адилхан л цэрэгжсэн байгууллага.

Тэгэхээр хяналт бол хаанаа ч үл ялгаварлах зарчмаар нэг жигд үйлчилж байх ёстой гэсэн утгаараа хэлмээр байна.

Өөр нэг Хүний эрхийн комисст хандаж хэлэх нэг санал байна. Хүний эрхийн. Одоо ингээд та нар нэг юмыг хараадхаарай. Батлан хамгаалах яам зөндөө л төсвөө оруулж ирээд л Сангийн яаман дээр бас цавчаад л хасчихсан байж байгаа.

Тэгтэл тэр төсөв дотор нь нөгөө саяын энэ хүний эрхийн наад захын хэрэгцээг хангаж байх орчин нөхцөл байдлыг сайжруулах төсвүүд зөндөө орсон байгаа. Тэр хэр хасагдсан байна. Тэрийг та нар үзээрэй.

Одоо яг үүнийг ашиглаж Сангийн яамтай ярьж дараагийн төсөв дээрээс нь ийм юм хасаж болохгүй шүү. Яагаад гэвэл үүнийг хасах болгоны ард чинь нэг аавын хүүхэд, нэг цэрэг тэнд даарч хөрч, ханиадтай хатгаатай явж байгаа шүү гэдгийг ойлгуулах хэрэгтэй.

Тэгэхээр тэр хүний эрхэд нийцсэн төсөв бий болгох тал дээр нь та нар зөвхөн өөрийн төсвөө биш. Одоо энэ

чинь ийм байгууллагуудын төсвийг батлуулах тал дээр та нар анхаарч ажиллаарай гэж хэлмээр байна.

Тэгээд энэ жендэрийн комисст ч гэсэн хандаад нэг зүйлийг хэлэхэд энэ яах хэрэгтэй. Хилийн цэрэг дээр бас танайхан очиж энэ нөхцөл байдлыг эртнээс үзэж харж, тэгээд энэ армийн ч, хилийн цэрэг дээр ч байгаа энэ бие бүрэлдэхүүний хүүхдүүдийн сургуулийн асуудал. Ялангуяа хилийн цэргийнхэн чинь тэр хол застав дээр ажиллаж байгаа хүмүүс. Хүүхдүүдийнх нь сургуулийн асуудал яаж байдаг юм бэ.

Энэ зүгээр л нэг барьж аваад шүүмжлээд байхаасаа гадна Монгол төр өөрөө хариуцлага хүлээгээд энэ дээр шаардлагатай нөхцөлийг нь хангаж өгч байгаа юу, үгүй юу. Түүнээс эндээс өндөр өндөр дуугаар өнгөрсөн борооны хойноос цув нөмрөх гээд хүн загнаад суугаад байх биш урьдчилаад тэр нөхцөлүүдийг нь хангаж өгч байх ёстой.

Энэ дээр тэгэхээр хүний эрхэд ээлтэй тэр төсвийн асуудал дээр онцгой анхаарч жендэрийн комисс ч гэсэн би ажиллаарай гэж энд захиж хэлмээр байна.

*Хуралдаан 2 цаг 28 минут үргэлжилж, 19 цаг 21 минутад өндөрлөв.*

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**

Тэгээд энэ бүгд хэлэлцүүлгийн ард би бас нэг зүйлийг хэлмээр байна. Мэдээж хүний эрх маш чухал. Тэгэхдээ цэрэг бол цэцэрлэг биш шүү.

Түүнээс ингээд очоод л нэг их сүрхий яриад энэ цэрэг чинь өөрөө хатуужилтай. Үүнээс хатуу ажил хийх зориулалттай. Тэр хүрээндээ ажиллаж байдаг газар учраас тэр хүний эрхийн хэм хэмжээгээ бүгдийг нь очиж дүгнэж өгөхдөө мэдээжийн хэрэг энэ бол өөрөө армийн дүрэмтэй, сахилга баттай ийм байгууллага шүү гэдгээ бас тал талдаа бодолцож ажиллах ёстой болов уу гэж бодож байна.

Их Хурлын даргын өгсөн чиглэлийн дагуу Хүний эрхийн комиссоос өнөөдөр үүсээд байгаа асуудал нөхцөл байдалтай холбогдуулаад танилцуулгыг сонслоо.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал өндөрлөсөн болохыг үүгээр мэдэгдэж байна. Хуралд оролцсон гишүүддээ баярлалаа.